

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-14
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	15-60

1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын 9 гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	15-41
2.Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай	41-60

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 06 дугаар сарын 10-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 45 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга;
Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Л.Мөнхбаатар.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хэлэлцэх асуудлын дарааллын 1 дүгээрт байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэхийг ажлын хэсэг хуралдаагүй тул хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14

57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэхийг хойшлуулав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарыг дэмжсэнээр тооцож, 64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Нэг.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, мөн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэлийн хэлтсийн дарга Ш.Цолмон, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Б.Өлзийсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны

Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, мөн албаны референт Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр үргэлжлүүлэн хэлэлцэв.

Нэг.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Өмнөх хуралдаанаар төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалттай холбогдуулан ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан саналууд дэмжигдээгүй тул Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан саналаар санал хураалт явуулав.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 17.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	0
Татгалзсан:	14
Бүгд:	14

0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан дээрх санал дэмжигдээгүй тул Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан саналаар санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 17.3.1 дэх заалтын “бусад” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	7
Бүгд:	14

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Д.Цогтбаатар: 3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 18.3 дахь хэсгийн “судалгаа, шинжилгээний байгууллага, судлаач” гэснийг “хууль зүй, төсвийн судалгааны чиглэлээр дагнан ажилладаг хүн, хуулийн этгээд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	6
Бүгд:	15

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27¹.2.Дараах асуудлаар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгохгүй:

27¹.2.1.Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хуулиар тогтоосноос гадуур хязгаарлах, хариуцлага оногдуулах;

27¹.2.2.Монгол Улсын Үндсэн хуульд гагцхүү хуулиар тогтоохоор заасан харилцаа;

27¹.2.3.эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа;

27¹.2.4.гомдол, маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хугацаа, оролцогчдын эрх үүрэг.

Тайлбар: гомдол, маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хугацаа, оролцогчдын эрх, үүргийг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд бусад асуудлыг захиргааны хэм хэмжээний актаар тогтоож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	7
Бүгд:	16

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гаргасан санал дэмжигдсэн тул уг заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориггоос Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹ дүгээр зүйлийг бүхэлд нь хасах гэсэн санал гаргасныг уншиж танилцуулж, санал хураалт явуулаагүй болно.

Д.Цогтбаатар: 5.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 28.3.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	0
Татгалзсан:	16
Бүгд:	16

0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 29.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.5.Энэ хуулийн 12.2.2-т заасан хуулийн төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл, холбогдох тооцооллыг хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гаргасан санал дэмжигдсэн тул уг заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалт буюу 29.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.5.Энэ хуулийн 12.2.2-т заасан хуулийн төслийг дагалдуулан Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай, Тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, аливаа төрлийн анхдагч болон шинэчилсэн хуулийн төсөл өргөн мэдүүлэхийг хориглох бөгөөд бусад хууль тогтоомжийн төсөл өргөн мэдүүлэх тохиолдолд тухайн төслөөр зөвхөн төсөв, санхүүгийн харилцааг зохицуулна.” гэсэн саналыг уншиж танилцуулж, санал хураалт явуулаагүй болно.

Д.Цогтбаатар: 7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу 33.3.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалт буюу 39.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“39.3.Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах зохицуулалт бүхий хуулийн төсөлд Хүний эрхийн Үндэсний Комиссоос, Эрүүгийн хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамтай холбогдсон хуулийн төсөлд Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокуророос тус тус санал авах ба ажлын 30 хоногийн дотор санал ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 9
Бүгд: 16
43.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7

Бүгд: 18
61.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалт буюу 39.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“39.3.Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах зохицуулалт бүхий хуулийн төсөлд Хүний эрхийн Үндэсний Комиссоос, Эрүүгийн хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамтай холбогдсон хуулийн төсөлд Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокуророос тус тус санал авах ба ажлын 30 хоногийн дотор санал ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: 9.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалт буюу 40.1.11, 40.1.12 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 14
Бүгд: 18
22.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 41.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг саналаа тайлбарлаж үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан санал дэмжигдсэн тул уг заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 41.4 дэх хэсгийг хасах гэсэн санал гаргасныг уншиж танилцуулж, санал хураалт явуулаагүй болно.

Д.Цогтбаатар: 11.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалт буюу 51.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 11
Бүгд: 19

42.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг саналаа тайлбарлаж үг хэлэв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “бүлэг, дэд бүлэг, зүйлийн” гэснийг “бүтцийн” гэж өөрчилж, “29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “боловсруулна” гэсний урд “анх батлагдсан хууль болон дагалдаж буй хуулийн төслийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлэн” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	6
Бүгд:	19

68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гаргасан санал дэмжигдсэн тул уг заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Төслийн 2 дугаар зүйлийн “29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “боловсруулна” гэсний өмнө “анх батлагдсан хууль болон дагалдаж буй хуулийн төслийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлэн гэж” гэснийг “29.3 дахь хэсгийн “шаардлагатай” гэсний өмнө “Тухайн батлагдах хуулийг хэрэгжүүлэхэд зайлшгүй” гэж, “боловсруулна” гэсний өмнө “тухайн хуулийн төслийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлэн” гэж” гэж өөрчлөх гэсэн санал гаргасныг уншиж танилцуулж, санал хураалт явуулаагүй болно.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 7.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	8
Бүгд:	19

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гаргасан санал дэмжигдсэн тул уг заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 7.5 дахь хэсгийг хасах гэсэн санал гаргасныг уншиж танилцуулж, санал хураалт явуулаагүй болно.

14.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 10
Бүгд: 19
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг саналаа тайлбарлаж үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан санал дэмжигдээгүй тул Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан саналаар санал хураалт явуулав.

15.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.6 дахь заалтын “сонирхолд нийцүүлэх зарчимд тулгуурлан” гэснийг “сонирхол, хууль тогтоомжид нийцэх эсэхийг дүгнэн оновчтой хувилбарыг үндэслэлийн хамт санал болгох зарчмыг баримтлан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 17.1 дэх хэсгийн “судалгаа, шинжилгээний байгууллага, судлаачаар” гэснийг “хөндлөнгийн судлаач, хуулийн этгээдээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 18.1.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын хэсгийн гаргасан санал дэмжигдсэн тул уг заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 17.1 дэх хэсгийг хасах гэсэн санал гаргасныг уншиж танилцуулж, санал хураалт явуулаагүй болно.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу 38.1 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 38.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.7.Хууль санаачлагч олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан, эс тусгасан талаарх саналын товъёгийг тайлбар, үндэслэлийн хамт албан ёсны цахим хуудсандаа болон хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим системд байршуулна. Хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим систем нь энэ хуулийн 45.3-т заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн нэг бүрэлдэхүүн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалтын 49.2 дахь хэсгийн “Засгийн газраас үүрэг болгосны дагуу” гэснийг хасаж, 7 дахь заалт буюу 40.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“40.3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115, 117, 118 дугаар зүйлд заасан тайлан, илтгэл нь энэ хуулийн 40.2-т заасан шаардлагыг хангасан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6
Бүгд: 19
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “15.7.1 дэх заалтын “иргэн, захиргаа,” гэснийг, 28.3.9, 28.8.6 дахь заалтын “шаардлагатай бол” гэснийг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулга бүхий зүйл нэмэх:

“7 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 11
Бүгд: 19
42.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төслийн талаарх ажлын хэсгийн гаргасан найруулгын саналаар санал хураалт явуулав.

Найруулгын санал

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “34 дүгээр зүйлийн” гэсний өмнө ““33.5 дахь хэсгийн “33.3.3-т” гэснийг “33.3.5-т” гэж,” гэж, “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө ““38 дугаар зүйлийн 38.2, 38.4 дэх хэсгийн “40.1.3-т” гэснийг “40.1.3, 40.1.4-т” гэж, 38.9 дэх хэсгийн “12.2.23, 12.2.24-т” гэснийг “12.4-т” гэж,” гэж, мөн төсөлд **“6 дугаар зүйл.**Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2.17, 12.2.24 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн зүйл нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.1.1 дэх заалтын “хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахад” гэснийг “хэрэгжүүлэхэд” гэж, 27¹.1.2 дахь заалтын “зорилтод” гэснийг “зорилт, үйлчлэх хүрээнд” гэж, 2 дугаар зүйлийн “жагсаасан” гэснийг “байрлуулсан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.1.5 дахь заалтын “үндсэн” гэснийг, 4 дүгээр зүйлийн “эх бичвэрийн” гэсний өмнөх “англи хэл дээрх” гэснийг, 5 дугаар зүйлийн “12 дугаар зүйлийн 12.2.17, 12.2.24 дэх заалтыг,” гэснийг тус тус хасаж, төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

Хоёр.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг санал хэлж, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нэмэлт тайлбар хийв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хүний эрх, эрх чөлөөг” гэсний өмнө “хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 10
Бүгд: 19
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хүний эрх, эрх чөлөөг” гэсний өмнө “хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар хариулж, тайлбар хийв.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Төсөлд доор дурдсан агуулга бүхий зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дөрөв.“Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр заалтын 2 дахь дэд заалтын “холбогдох хуулиудын төслийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан” гэснийг “судалгаа хийж, холбогдох хуулиудын төслийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд” гэж өөрчилж, энэ заалтад доор дурдсан агуулгатай 4 дэх дэд заалт нэмэх:

“4/хууль санаачлагчид мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий төрийн холбогдох байгууллагын албан хаагчдыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан холбогдох аргачлал, арга зүйгээр хангах, чадавхжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	9
Бүгд:	19

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Их

Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын удирдлагад даалгасугай:

1/хуулиар тусгайлан эрх олгогдоогүй бөгөөд нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг хүчингүй болгох;

2/хуульд заасны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;

3/эрх зүйн зохицуулалтын ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, хууль тогтоомжтой зөрчилдсөн, эрх олгосон хуулийн заалт нь хүчингүй болсон, өөрчлөгдсөн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, хуульд нийцүүлэн шинэчлэн батлах;

4/эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг, сонирхлын зөрчил, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн шинжтэй дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	8
Бүгд:	19

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмэх:

“6.Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг нийтийн эрх зүйн этгээдэд зөвлөсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	8
Бүгд:	19

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Оч, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Э.Золзаяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг нэр дэвшигчдийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, С.Эрдэнэболд нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Оч, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Э.Золзаяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их хурлын гишүүн С.Эрдэнэболд, Д.Ганбат, П.Сайнзориг нар үг хэлэв.

Уг асуудлыг 13 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 35 минут үргэлжилж, 22 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 86.4 хувийн ирцтэйгээр 13 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 10 цаг 45 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооныхоо хуралдааныг эхлүүлье.

Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан ийнхүү эхэлж байна аа. Ирц бүрдсэн тул ирц 59.1 хувьтайгаар бүрдсэн байна. Ингээд хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Ирц Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Энхтайваны Бат-Амгалан, Хүрэлбаатарын Баасанжаргал, Батжаргалын Заяабал, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтүяа, Бөхчулууны Пүрэвдорж, Ухнаагийн Отгонбаяр, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Даваагийн Цогтбаатар, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн ийм ирцтэйгээр бүрдсэн байна аа.

Ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаа танилцуулъя аа. Өнөөдөр 3 асуудал хэлэлцэхээр уг нь төлөвлөсөн байсан.

Нэгдүгээр асуудал. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг байсан.

Хоёр дахь нь Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар нарын 9 гишүүн 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг байгаа.

Гурав дахь асуудал нь Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшихтэй холбоотой ийм танилцах асуудал байгаа.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу? Алга байна.

Би тэгэхээр өөрөө шууд санал горимын санал гаргаад явчихъя. Тэгээд санал хураах нь зөв байх.

Нэгдүгээр асуудал энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд энэ ажлын хэсэг хуралдаж амжаагүй байгаа юм байна. Тэгэхээр өнөөдөр хэлэлцэх зүгээр техникийн боломж бүрэлдээгүй байна.

Тийм учраас энэ асуудлыг хэлэлцэх асуудлаас хасъя гэсэн горимын санал гаргаж байна. Санал хураалт явуулъя.

Ингээд саяын гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Энэ чинь нөгөө шинэ санал хураалтын горимын дагуу эхлээд санал хураалтдаа гишүүд бэлтгэе.

Санал хураалт.

Минийх орсонгүй. 57.1 хувиар санал дэмжигдлээ. Тэгэхдээ би дэмжиж өгсөн дэмжиж өгснөөр бүртгээрэй.

Ингээд санал дэмжигдсэн тул 2 асуудал үлдсэн. Хууль тогтоомжийн тухай хууль тэгээд Дээд шүүхийн шүүгчдийн асуудалтай танилцана.

Тэгэхлээр одоо нэгдүгээр асуудал. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя аа. Түрүүний хурал дээр та бүгд санаж байгаа. Хэлэлцүүлгийг түр завсарлуулсан байгаа.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Энэ хуралдаанд ажлын хэсэг ямар хүмүүс байна? Ажлын хэсэг ороорой. ХЭҮК-ын дарга Сүнжид, Нийслэл дэх засгийн захиргааны хэргийн анхан шатын шүүхийн шүүгч Мөнх-Эрдэнэ, Улсын Их Хурлын даргын зөвлөх Отгончимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Дондогмаа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Жамъянхүү, НЗД-ын Тамгын газрын Хууль эрх зүйн газрын дарга Үнэнбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Агар-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэлийн хэлтсийн дарга Цолмон, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Өлзийсайхан, ХЭҮК-ын Судалгаа дүн шинжилгээний хэлтсийн дарга Тунгалагтамир, Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч Одгэрэл, Монголын өмгөөлөгчдийн холбооны нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга Энхбаяр, Монголын хуульчдын холбооны гишүүн өмгөөлөгч Болд, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч Солонго, Нээлттэй нийгэм форум ТББ-ын засаглалын хөтөлбөрийн менежер Эрдэнэчимэг гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирж оролцож байна аа.

Ажлын хэсгийг танилцуулж, албан тушаалтнуудыг танилцуулж дууслаа. И Ингээд Хууль зүйн байнгын хороо 2025 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа уг хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлсэн бөгөөд өнөөдөр үргэлжлүүлэн хэлэлцэхээр байна аа.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр үргэлжлүүлэн хэлэлцье ээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн нэг дэх заалт болон төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалттай холбогдуулан санал хураалт явуулж эхэлсэн байгаа.

Ингээд төслийн 1 дүгээр зүйлийн нэг дэх заалттай холбогдуулан өмнөх хуралдаанаар ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүн Жаргалангаас гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулсан боловч Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул Улсын Их Хурлын гишүүн Сайнзоригоос гаргасан саналаар үргэлжлүүлэн санал хураалт явуулъя аа.

Ингээд төслийн 1 дүгээр зүйлийн нэг дэх заалтын 17.3 дахь хэсгийг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Нөгөө ажлын хэсгийн ахлагчийн хувьд ажилласны хувьд энэ дээр нэг тайлбар хэлсэн нь дээр байх гэж бодож байна. Бид нар ер нь 3 гишүүнээс санал ирсэн. Сайнзориг гишүүн, Жаргалан гишүүн, Энхтүвшин гишүүдээс яг энэ хуультай холбоотой саналууд ирсэн. Тэгээд авч болох хэмжээний саналуудыг аваад өөрсөдтэй нь ярилцаад юунуудыг боломжгүй үзэл баримтлалын хүрээнд яг энэ хуулийн гол чухал зорилго болгож байгаа зүйлүүдийг хасах саналыг бол дэмжих боломжгүй гэдэг байдлаар бол энд гишүүдийн гаргасан саналын томьёолол байгаа.

Тэгэхээр төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой Сайнзориг, Энхтүвшин гишүүдийн ингээд санал хураагдах байх. Ер нь бол товчхондоо хэлэхэд 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 41.4-тэй холбоотой Энхтүвшин гишүүн, Сайнзориг гишүүнээс гарснаас бусад саналыг бол ажлын хэсэг дэмжих боломжгүй гэж дүгнэж ярилцсан гээд гэдгийг бас хуралдаанд оролцож байгаа та бүхэндээ хэлсэн нь зүйтэй байх. 17.3 бол яг энэ хуулийн үзэл баримтлалд туссан хүний эрхийг одоо хууль тогтоомждоо хууль боловсруулагч маань ямар аргачлалаар дүн шинжилгээ хийж оруулах вэ гэсэн ийм шалгуур байгаа учраас энийг хасах боломжгүй байгаа гэдгийг хэлмээр байна аа.

Д.Цогтбаатар: Би түрүүн зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулсан байгаа. Тэгээд одоо энүүгээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Түр хүлээж байгаарай. Санал хураалтыг түр зогсооё. Энэ чинь нөгөө юу өөрчлөгдчихөөд одоо тэгэхээр яана гэнэ ээ. Шинэ системтэй сайн дасаагүй байгаа учраас ахиад яана гэнэ ээ. Манайхан бэлдүүлнэ гэдэг нь юуг хэлээд байгаа юм? Санал хураалтад бэлдээрэй. Тэгэхээр хуруугаа уншуулах ёстой юу энэ дээр.

Ингээд түрүүн саналын томьёоллыг уншаад танилцуулсан байгаа.

Санал хураалт.

Ингээд санал дэмжигдсэнгүй. Тийм учраас өмнөх санал ингээд босож байна гэсэн үг. Энэ дээр нэг ч дэмжсэн гишүүн байхгүйгээр санал дэмжигдсэнгүй ээ.

Саяын санал унасан учраас Улсын Их Хурлын гишүүн Сайнзоригийн гаргасан санал дэмжигдээгүй тул Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшиний гаргасан саналаар санал хураалт явуулъя аа.

Тэгэхээр зарчмын зөрүүтэй санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 17.1.3 дахь хэсгийн бусад гэснийг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Одоо тэгэхээр санал хураалтдаа бэлдэх үү?

Санал хураалт.

Хөөе энэ санал чинь уначихлаа шүү дээ, уначихлаа. Би дэмжсэн Да.Цогтбаатарын эсрэг, Даваагийн Цогтбаатарын эсрэг гарч байна. Тэгвэл энэ санал уналаа. 50 хувиар энэ санал унаж байна. Ингээд санал хураалт сая 50 хувиар уналаа.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшинээс гаргасан саналаар санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 18.3 дахь хэсгийн “судлаач” гэснийг “эсхүл хууль зүй, төсвийн судалгааны чиглэлээр дагнан ажилладаг хүн хуулийн этгээд” гэж өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Одоо шууд санал хураалт явуулчхаж болно тийм үү?

Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя аа.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27¹.2.Дараах асуудлаар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгохгүй:

27¹.2.1.Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хуулиар тогтоосноос гадуур хязгаарлах, хариуцлага оногдуулах;

27¹.2.2.Монгол Улсын Үндсэн хуульд гагцхүү хуулиар тогтоохоор заасан харилцаа;

27¹.2.3.эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа;

27¹.2.4.гомдол, маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хугацаа, оролцогчдын эрх үүрэг.

Тайлбар: гомдол, маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хугацаа, оролцогчдын эрх, үүргийг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд бусад

асуудлыг захиргааны хэм хэмжээний актаар тогтоож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Энэ чинь ингээд нийлүүлээд л нэг багцаараа санал хураалт хураагаад явж байгаа юм.

Санал хураалт дэмжье гэсэн томьёоллоор.

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Одоо энэ дээр чинь ажлын хэсгийн санал дэмжигдсэн тул уг заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Сайнзоригийн гаргасан саналыг уншиж танилцуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол

Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹ дүгээр зүйлийг бүхэлд нь хасах. Ээ томьёоллоор юу санал хураалт явуулъя.

Санал хураалт. Тийм тийм.

Дөрөвдүгээр зүйл.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Сайнзоригийн гаргасан саналаар санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалтын 28.3.6 дахь заалтыг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал дэмжигдсэнгүй, нэг ч гишүүн дэмжээгүй тул санал дэмжигдсэнгүй ээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн заримын зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 29.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

29.5.Энэ хуулийн 12.2.2-т заасан хуулийн төслийг дагалдуулан зөвхөн тухайн жилийн төсөвт нөлөөлөл үзүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийн төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл холбогдох тооцооллын хуулийн төслийн танилцуулгад тодорхой тусгана гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

56.3 хувиар санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн санал дэмжигдсэн тул уг заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан, Сайнзориг нараас гаргасан саналыг уншиж танилцуулъя аа.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 29.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

29.5.Энэ хуулийн 12.2.2-т заасан хуулийн төслийг дагалдуулан Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай, тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн төсөөллийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хууль, аливаа төрлийн анхдагч болон шинэчилсэн хуулийн төсөл өргөн мэдүүлэхийг хориглох бөгөөд бусад хууль тогтоомжийн төсөл өргөн мэдүүлэх тохиолдолд тухайн төслөөр зөвхөн төсөв санхүүгийн харилцааг зохицуулна.

Ажлын хэсгийн санал дэмжигдээгүй тул Улсын Их Хурлын гишүүн Жаргалангийн гаргасан саналаар санал хураалт явуулъя.

Тийм энийг ингээд бид нар нөгөө түрүүний санал дэмжигдсэн тул энийг чинь би уншиж танилцуулж байгаа. Би одоо бас нэг саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8.2 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэг.

29.5.Энэ хуулийн 12.2.2-т заасан хуулийн төслийг дагалдуулан бусад хууль тогтоомжийн төсөл өргөн мэдүүлэх тохиолдолд тухайн төслөөр зөвхөн төсөв санхүүгийн харилцаа зохицуулна гэснийг хасах. Уншиж танилцууллаа.

Энэ саяын саналыг Сайнзориг гишүүн гаргасан байгаа.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн заримын зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 33.3.3 дахь заалтыг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Манайх ажлын хэсгийнхээ юуг дэмжээд явна шүү. 62.5 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна аа.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалт буюу 39.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

39.3.Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах зохицуулалт бүхий хуулийн төсөлд ХЭҮК-оос Эрүүгийн хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамтай холбогдуулан хуулийн төсөлд үг нэмчхэж байгаа юм уу? Хаана нэмж байгаа юм? ингээд Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль болон Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамтай холбогдсон хуулийн төсөлд Улсын Дээд Шүүх, УЕП-оос тус тус санал авах ба ажлын 30 хоногийн дотор санал ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт хийе.

Саяын санал ингээд уналаа. Санал дэмжигдсэнгүй ээ. Энд байна шүү дээ зүгээр 1 нэгэндээ хүндэтгэлтэй хандъя. Хууль зүйн байнгын хороонд үгүй үгүй энэ Дээд шүүхээс нь саналыг нь авлаа. Нэг хүнд тааруулж 22 хүн нялцганаж ажиллана гэж байхгүй. Зүгээр л санал хураалтаа явуулъя. Өөрт чинь таалагдахгүй бол тэгээд л санал хураалтаараа. Санал чинь уначихлаа шүү дээ. Би одоо энэнээс илүү яах ёстой вэ? Яалгах гэсэн юм надаар. Би тэр саналыг чинь өөрийнхөөр чинь яваад уначихлаа. Та тэгээд горимын санал гаргаж байгаа юм уу? Тэгвэл яг үнэн. Яагаад гэвэл ажлын санал Дээд шүүх бүгдээрэнтэй нь ажиллаад тэр хариуцсан байгууллагууд нь саналаа өгчихсөн байгаа байхгүй юу. Болно гээд. Тэгсэн 1 л гишүүн болохгүй би мэдэж байна. Монгол Улсын шүүх энд хуулиар төгссөн өчнөөн хуульчид энд судлаачдаас энэ хүнээс хэд дахин илүү хэвлэгдсэн судлаачид энд болно гээд хэлээд байхад чинь нэг хүн л болохгүй гээд унаж байгаа байхгүй юу. Би тэрийг гайхаж байгаа юм.

Ганбат гишүүн горимын саналаа гаргая.

Д.Ганбат: Одоо сүүлийн үед ч юу болоод байна аа. Энэ Улсын Их Хурлын чуулганаар бүүр хэлэлцэх асуудалгүй болчихсон ч байх шиг. Тэгээд манай Байнгын хороо хэвийн хуралдаад байдаг байсан. Өмнөх Байнгын хороо чинь нэг их олигтой болж чадаагүй байх тиймээ. Манай Байнгын хорооны дарга энэ талаар нэлээн ярьж байсан. Цаашдаа ер нь яаж энэ Байнгын хороо хуралдах юм бэ гээд. Сая ч гэсэн санал хураалтад заримдаа гацдаг юм уу яадаг юм. Би дэмжсэн чинь минийх эсрэг гарчихсан байна горимын санал гаргаж байна ахиад санал хураалгаж өгнө үү.

Д.Цогтбаатар: Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

61.3 хувиар санал дэмжигдлээ.

Д.Ганбат: Тэгэхээр түрүүн саналын томьёоллыг уншиж танилцуулсан байгаа. Тэгэхээр дахиж уншъя. Би дахиад уншаад танилцуулчихъя.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дүгээр заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэгдсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна аа.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалт буюу 39.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

39.3.Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах зохицуулалт бүхий хуулийн төсөлд ХЭҮК-оос Эрүүгийн хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамтай холбогдсон хуулийн төсөлд Улсын Дээд шүүх, УЕП-оос тус тус санал авах ба ажлын 30 хоногийн дотор санал ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд ажлын хэсгийн санал дэмжигдсэн тул уг заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан, Сайнзориг нараас гаргасан саналыг уншиж танилцуулъя аа.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн нэг дэх заалт буюу 39.3 дахь хэсгийг хасах.

Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтыг хасах. Энэ санал гаргасан Сайнзориг гишүүний санал байгаа юм.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Сайнзоригийн гаргасан саналаар санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалт буюу 40.1.11, 40.1.12 дахь заалтыг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

Санал хураалт.

Санал дэмжигдсэнгүй, 22.2 хувиар.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Сайнзоригийн гаргасан саналаар санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 41.4 дэх хэсгийг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал гаргасан Сайнзориг.

Эхлээд Сайнзориг гишүүн үгээ хэл.

П.Сайнзориг: Би яах вэ ажлын хэсгийн гишүүдийг жоохон сэтгэл гаргаад ажилласан бол ийм юм гарахгүй байсан юм. Би түрүүчийн хурал дээр орилж байж хэдэн саналуудыг засуулж энэ захиргааны хэмжээний актын эрх тусахгүй гээд. Өнөөдөр гагцхүү хуулиар зохицуулсан асуудлаар захиргааны хэмжээнд гаргахгүй ч гэдэг юм уу. Энэ маргаан ингээд эцэстээ юу руу орох гэж байна гэхээр Үндсэн хууль дээр байдаг хоёрхон заалтад зориулж ийм заалт хийж байгаа энэ журмуудыг байхгүй болгоод цөөрүүлэх гэж байгаа гэж худлаа пи ардаж байгаа байхгүй юу. Одоо наад пи араа зогсоочих. Энэ хуулиар тэр юм чинь шийдэгдэхгүй.

Би энэ заалтынхаа хувьд зүгээр тайлбарлая Улсын Их Хурлын Тамгын газар нь Судалгааны асуудал эрхлэх хүрээлэн нь энэ хуулийн 17.2.4-д заасан хууль тогтоомжийн төслийн эрх хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ аргачлал 17.3-д заасан хийгдсэн хэсэгт ажлын 5 өдөрт дүгнэлт гаргана гэж байгаа юм. Би энэ дээрээс татгалзахгүй. Тэгэхдээ энэ процессуудыг би уг нь Цогоо даргад хэлж байсан байхгүй юу. Ажлын хэсэг гараад Улсын Их Хурал хэлэлцэхээ шийдсэний дараа ийм дүгнэлтүүдийг гаргах нь зохимжтой. Өргөн барих гэж байхад нь Улсын Их Хурлын Тамгын газар ингээд үзэмжээрээ янз бүрийн юм ингээд хууль санаачлагчийн Үндсэн хуулийн эрхэд халдаад байж болохгүй байхгүй юу даа. Тэгээд энийг Цогоо дарга би зүгээр ингээд ийм завхарсан юмыг ингээд орж ирээд засчихъя гэхээр засуулахгүй ингээд маш олон юмнууд нь явчихлаа.

Одоо ингээд захиргааны ажилчид хууль санаачлагч буюу Ерөнхийлөгчийн барьж байгаа, гишүүдийн барьж байгаа засгийн барьж байгаа хуулиудын асуудал дээр ийм үзэмжээрээ дүгнэлт гаргадаг юмнуудыг ингэж оруулж байна шүү дээ. Энэ сүүлдээ ингээд зай завсаргүй хэрүүл болно. Буцаая гэсэн хууль дээрээ янз бүрийн шалтаг олж янз бүрийн юм бичүүлнэ. Магадгүй энэ алба хаагчаас сүүлдээ эрсдэлд орох байхгүй юу. Нэг сонин юм бичдэг ингэж улс төрчид нь сүүлдээ арьсаа хамгаалахгүй шүү дээ. Энэ ажилчид дээр ийм буруу юм биччихжээ гээд үүрүүлнэ. Тэгээд хууль санаачлагчийн ийм эрхийг ийм субъектив байдлаар хязгаарлаж болохгүй. Харин ажлын хэсэг гараад хэлэлцэх эсэхээ шийдээд энэ дээр ийм асуудлаар нь дүгнээдэх гэж болно. Судалгаан дээр юу гэж байсныг дүгнээд гаргаад ирье гэж хэлж болно.

Тэгэхээр ийм зүйлүүд байгаад байгаа юм. Тэгээд энэ ийм юмнуудыг хасаж орж ирэхгүй бол ингээд ер нь хууль санаачлагчийн эрхийг ингээд Улсын Их Хурлын Тамгын газрын захиргааны хэдэн экспертийн алба гээд хүмүүсийн гарт өгч болох юм уу?

Д.Цогтбаатар: Ингээд түрүүн томьёоллыг уншиж танилцуулсан, тэгээд Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Сайнзоригийн гаргасан санал дэмжигдсэн тул уг заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшингийн гаргасан саналыг уншиж танилцуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалт буюу 41.4 дэх хэсгийг хасах.

Цаашаа үргэлжлүүлээд явъя.

10.Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Сайнзоригийн гаргасан саналаар санал хураалт явуулъя аа. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дахь заалт буюу 51.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя аа.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

Санал хураалт.

Санал хураалтыг түр зогсооё. Санал гаргасан гишүүн өөрөө тайлбараа хэлье гэж байна. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Ийм байгаа юм аа. Энэ асуудал уг нь аливаа хуулийг батлан гарснаас хойш 5 жил дотроо. Эсвэл хууль тогтоогчоос заасан хугацаанд нэг жил ч байж болно. Хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж Улсын Их Хуралд танилцуулаад энэ хуулийг цаашдаа ямар байдлаар сайжруулах вэ нэмэлт, өөрчлөлт оруулах уу үгүй юу гэдэг асуудлыг шийдэх юм. Тэгэхээр энэ хуулиар юу орж ирж байна гэхээр тэр заалтаа үгүйсгээд 51 дээр байгаа. 51.1 дээр байгаа заалтаа үгүйсгэнгүүтээ 5 түүнээс дээш жил дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийг шинэчилсэн найруулга тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийж энэ хуулийн 52 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээний үр дүнг хэлэлцүүлсэн байна л гэж байгаа юм. Угаасаа 5 жил дотроо хийх ёстой ажлуудыг хэдүүлээ 5-аас дээшээ хийж болно л гээд байгаа юм. Зүгээр магадгүй энэ Хууль тогтоомжийн хууль батлагдахаас өмнө батлагдсан хуулиудыг яах вэ гэдэг асуудлыг зүгээр бид нар нэг чиглэл өгч болно.

Тэгэхээр энэ өөрөө эргээд 5 жил дотроо ерөөсөө аливаа асуудлуудыг хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийж Улсын Их Хуралд танилцуул гэдэг зүйлийг байхгүй болгоод хаячхаж байгаа байхгүй юу.

5 түүнээс дээш гээд. Тэгэхээр энийгээ зүгээр хасчхаач. Зүгээр хэдүүлээ 5 жил гэдэг зүйл дээр нь мөрдүүлэх ёстой байхгүй юу. Яагаад бид нар энэ хэрэгжилтийн үр дагаврыг 5 жил тутамд парламент хэлэлцье гэхээр түүнээс 5 жилээр байхгүй байж болно 5 түүнээс дээшээ байж болно гээд ингээд энэ 51.5-аар нь зааж гаргаж өгөөд байгаа юм бэ? Энийг ингээд байж болохгүй энийг хасъя л гэж байгаа юм. Хариулж болохгүй би зүгээр тайлбараа л хэлж байгаа юм л даа. Одоо хэдүүлээ ингээд процессоороо л явъя. Би зүгээр энийг гишүүд анзаараасай. Хэрэгжихгүй

байгаадаа биш, хэрэгжүүлэх институт хэдүүлээ Улсын Их Хурлаас их юм байгаа. Энэ дээр төсөв мөнгийг нь тавьж өгөх ёстой, шаардахгүй байна.

Дээрээс нь энийг хийгээд ерөөсөө ач холбогдол өгөхгүй байгаа байхгүй юу. Нэг талдаа хүний эрхийн үндэсний тайлангаас орж ирж байгаа ч тайлан энэний нэг хэсэг л явж байгаа. Тэгээд 5 жил тутам хийж байгаа юмнуудыг хийхгүй байж болно гэдэг ийм заалт оруулж ирж байгаа нь бүр ухарч байгаа байхгүй юу. Тэгэхээр хэдүүлээ энийгээ зүгээр хэрэгжүүлээд явах ёстой. Харин Засгийн газар хууль хэрэгжүүлж байгаа байгууллагуудаа шахаж ажиллах. Магадгүй энэ 5 жилээс хэтэрч байгаа байх юм бол бид нар ч гэсэн цааш цаашдаа энийгээ төлөвлөгөө гаргаад танилцуул гэж шахна уу гэхээс биш ийм зүйл байж болохгүй.

Тэгэхээр энийгээ бараг хасчихъя аа. Одоо энэ дээр асуулт хариулт байхгүй шүү дээ. Би зүгээр саналаа тайлбарлаж байгаа юм.

Д.Цогтбаатар: Тийм санал гаргасан гишүүн л тайлбар хийх горимын юутай зохицуулалттай. Тийм учраас өөр тайлбар юм байхгүй. Түрүүн саналын томъёоллыг уншаад танилцуулчихсан. Ингээд дэмжье гэснээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

42.1 хувиар санал дэмжигдсэнгүй.

Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Ингээд төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсэг 1, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан 1 зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн байгаа.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Мэдээж хуулийг сайжруулаад явахыг би дэмждэг. Байнгын дэмждэг. Тэгэхдээ яг энийг нөгөө судалгаа, хэрэглээний асуудлыг нь зөв тооцож байж хийхгүй бол ийм дутуу дулимаг янз бүрийн юмаар хийхээр ийм нөхцөл байдлууд үүсэж байгаа юм аа. Зарим асуудлыг аргачлалын хүрээнд шийдээд явж болно. Бид хэд энэ хууль тогтоомжийн төслийг боловсруулахдаа Засгийн газрын баталсан 2017 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалуудыг бариад явдаг юм аа. Энэ аргачлал дээр байж болох хамгийн инээдтэй нь бүүр ингээд хуулийн төслийн бүтэц дээр бүтцийн нэг хэсэг нь товъёг гэж орж ирж байгаа байхгүй юу. Ийм ийм сонин сонин. Тэгээд энийгээ ингээд одоо ярихаар л энэ ажлын хэсгээс би хариулаасай гэж бодож байна. Би зүгээр ядаж ийм саналуудыг битгий оруулаач ээ. Хуулийн бүтэц чинь гарчиг тиймээ тэгээд Бүлэг, Дэд бүлэг, хэсэг, зүйл хэсэг, заалт, дэд заалтаас бүтэж байгаа байхгүй юу. Товъёгоос бүтэхгүй. Тэгээд ингээд ийм редакцын юмнуудыг нь хэлэхээр ингээд бид судалгаатай бид мэдэж байна гээд ингээд зөрүүдлээд, хууль санаачлагч гишүүдийг худлаа мэдээллээр хангаад, ийм юмнууд оруулж ирчхээд байх юм. Тэгээд энэ яг сүүлүүдээ ингээд засаж байгаа юм байгаа юу? Ер нь энэ хуулиудаар ингээд явлаа. Сая орилж байж засуулж байгаа шүү.

Төсвийн хуулийг дагаад бүүр ямар ч хуулиуд өргөн барихгүй болгож байсан. Төсөв гэдэг бол жинхэнэ улс төрийн бичиг баримт. Тэр төрийн байгууллагыг хасчхаж болно, татварыг нэмж болно, бууруулж болно, дагаад холбогдох хуулиудад нь өөрчлөлт оруулж болох байхгүй юу. Гэтэл энийг өөрчлөлт орохгүй. Сая нэг өөрчлөлт найруулаад нэг ийм сонин л юм боллоо. Тэгэхдээ төсвийн хуулийн асуудлыг уг нь төсвийн хууль, төсвийн тогтвортой байдлын хууль дээрээ л зарчим нь байх ёстой. Бид хэд энд ингээд холилдуулаад, зарчим алдагдуулаад, ийм л нөхцөл байдалтай болгож байна.

Д.Цогтбаатар: Номинчимэг хариулъя. Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: 1 дүгээрт Сайнзориг гишүүн яг энэ 2 дугаар бүлэгтэйгээ холбоотой л үг хэлмээр байна. Түрүүн санал хураачихсан төсөвтэй холбоотой асуудлыг энд ерөөсөө хольж хутгамааргүй байна. Та ч мэдэж байгаа. Төсөв дагуулаад төсөвтэй ямар ч хамаагүй янз бүрийн юм л дагуулж орж ирдэг л байсан шүү дээ. Тэрийг чинь бүгдээрэнг нь засаад төсөвт л үнэхээр холбоотой нөлөөлөл үзүүлэх ийм юмаа л дагуулж орж ирье гэж байгаа. Тэгээд энэ нь ч угаасаа сая гишүүдээр дэмжигдээд зарчим угаасаа ийм учраас ингээд явчхаж байгаа.

Бүтэцтэй холбоотой юман дээр энэ жоохон найруулгын юм орж ирж байгаа. Саяын энэ 2 дугаар бүлэг таны үг авсан хэсэг бол. Хуулийн төслийн бүтэц тэгээд бүтцийн товьёг ингээд болгож байгаа. Энэ дээр яах вэ энэ нөгөө хуулийн төслөөр юу шинэчил хийж байгаа вэ гэхээр бид нар яах вэ ингээд зүйл, заалт гээд ингээд явдаг боловчиг товьёгтой болъё гэж байгаа нөгөө гаднын хуулиуд шиг. Яг аль зүйл, заалт нь юутай холбоотой юм бэ гэдгийг ойлгомжтой болгоод хүнд хэрэглээнд, хууль тогтоомжийг хүний хэрэглээнд илүү ойлгомжтой нийцүүлэх байдлаар товьёгтой болъё. Аль аль зүйл заалт нь ямар харилцааг зохицуулаад байгаа, ямар эрх хэсэг нь тэрэн дээр байгаа гэдэг юмыг л оруулж ирье гэдэг юм байгаа. Тэрний л найруулгын юмнууд бол энэ 2 дугаар зүйл дээр засагдаж орж ирж байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Тэр товьёгтой зөв байх аа. Яагаад гэвэл одоо жишээлбэл Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрүүд гэхэд хэдэн мянган хуудас байдаг байхгүй юу. Тэгээд хэрэгтэй хэсгээ олохын тулд товьёггүйгээр олохгүй. Энэ чинь аягүй хэцүү байхгүй юу. Тэр хэлэлцээрүүд чинь тийм учиртай байдаг юм аа. Яах вэ би сая ойлголоо. Ингээд хэдүүлээ цаашаа ажлаа үргэлжлүүлээд явъя.

11.Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураа хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 2 дугаар зүйлийн “бүлэг, дэд бүлэг, зүйлийн” гэснийг “бүтцийн” гэж өөрчилж, “29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “боловсруулна” гэсний урд “анх батлагдсан хууль болон дагалдаж буй хуулийн төслийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлэн” гэж,” гэснийг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

68.4 хувиар санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн бэлтгэсэн санал дэмжигдсэн тул уг заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан Жаргалан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан, Сайнзориг нарын гаргасан саналыг уншиж танилцуулъя аа.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 2 дугаар зүйлийн “29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “боловсруулна” гэсний өмнө “анх батлагдсан хууль болон дагалдаж буй хуулийн төслийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлэн гэж” гэснийг “29.3 дахь хэсгийн “шаардлагатай” гэсний өмнө “Тухайн батлагдах хуулийг хэрэгжүүлэхэд зайлшгүй” гэж, “боловсруулна” гэсний өмнө “тухайн хуулийн төслийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлэн” гэж” гэж өөрчлөх. Санал гаргасан Жаргалан гишүүн байгаа.

Саяын энэ юун дээр Сайнзориг гишүүн гаргаагүй. Жаргалан гишүүний гаргасан санал байна шүү. Андуураад уншчихсан байна.

Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсэг 5, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг 1, Энхтүвшин гишүүн 3 зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн байна аа.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

12.Төслийн 3 дугаар зүйлийн нэг дэх заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя аа.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн нэг дэх заалтын 7.5 дахь хэсгийг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн бэлтгэсэн санал дэмжигдсэн тул уг заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшиний гаргасан саналыг уншиж танилцуулъя аа.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн нэг дэх заалтын 7.5 дахь хэсгийг хасах.

Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Сайнзоригийн гаргасан саналаар санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.6 дахь заалтыг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг. Сайнзориг гишүүнд микрофон өгье.

П.Сайнзориг: Би энэ дээр байгаа агуулгыг бол ерөөсөө эсэргүүцээгүй. Агуулга бол ерөнхийдөө заавал хийгдэх ёстой. Энэ 13-д одоо хүчин төгөлдөр хуулийн 13 дугаар зүйл дээр байж байгаа.

13.2 буюу энэ хуулийн 12.1-д заасан аргачлалаар дараах асуудлыг судалж зөвлөмж гаргана гээд ингээд байж байгаа байхгүй юу. Энэ дээр нь угаасаа энд дурдагдаад байгаа зүйлүүдийг тусгах юм. Одоо харин бүрдүүлбэр дээр болон нөгөө нэг Улсын Их Хурлын Тамгын газрын дүгнэлт дээр энэ судалгаануудыг чинь барьж шийдэж байгаа шүү дээ. Ингэсэн байна тэгсэн байна. Энэ дээр юу орж ирэх гэж байна гэхээр судалгааг үндсэндээ хязгаарлаж эхэлж байгаа. Өөрөөр хэлэх юм бол шаардлагатай тохиолдолд тухайн асуудалд гадаад улсын хууль тогтоомжийн зохицуулалтын талаар харьцуулсан судалгааг үндэсний эрх зүйн тогтолцооны уламжлал, онцлог, хөгжлийн чиг хандлага болон эрх зүйн бус соёлын төсөөтэй, ялгаатай байдлыг харгалзан үндэсний ашиг сонирхолд нийцүүлэн цаашид тулгуурлан хийх гээд яаж судалгаа хийх вэ гэдэг зүйлийг ингээд хашиж өгөөд байгаа байхгүй юу. Энэ судалгааг аль ч орны эрх зүйн тогтолцоотой, зохицуулалттай харьцуулж хийж болно.

Энийг авах авахгүй нь өөрөө хууль санаачлагчийн бүрэн эрх. Энийгээ тайлбараа өгөх нь хууль санаачлагчийн бүрэн эрх байхгүй юу. Гэтэл өнөөдөр зөвхөн өөрийнхөө эрх зүйн бүлгийг судална гээд байдаг. Дэлхий дээр байгаль орчны салбар, эдийн засаг, санхүүгийн салбар чинь эрх зүйн бүл хамааралгүйгээр нэг болчихсон. Яагаад гэхээр олон улсын эрх зүйн хөгжлийнхөө дагуу. Гэтэл бид нар өнөөдөр ийм зүйл дээр эрх зүйн бүл яриад зөвхөн чи бүлгийнхээ орныг судалж байж энэ дүгнэлт дээр тусгана энэ тэр гээд байхаар бүх зүйлүүдийг ингээд хумиад байна аа. Жишээ нь манай бүх Төсвийн хуулиуд, Төрийн албаны хуулиуд чинь бүгд Канад, Австрали, Нью Зеландаас авсан байдаг. Бид хэд зүгээр ийм иймэрхүү юмнаас авах авахгүй нь өөрөө хууль санаачлагч магадгүй тэр хуулийг батлах батлахгүй нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал байхгүй юу. Судалгааг хүртэл ингэж одоо яг яах гээд байгаа нь мэдэгдэхгүй ийм байдлаар оруулж болохгүй.

Би энийг юу хийгээд байгааг ерөөсөө ойлгохгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ гарч ирсэн судалгааг авах авахгүй нь хууль санаачлагчийн эрх, тухайн хуулийг батлах батлахгүй нь хууль тогтоогчийн эрх. Судалгааг ингэж хийнэ шүү зөвхөн эрх зүйн бүлгийнхээ орныг хийе, чиг хандлагатайгаа нийцэж байна уу үгүй юу гэдэг ийм ийм юм ерөөсөө байж болохгүй ээ. Тэгээд энэ зарим тунгалаг аль нэгээ зөвхөн сонгодог эрх зүй байхаа больчихсон. Ялангуяа байгаль орчны эрх зүй, санхүү, хүний эрхийн зарим чиглэлийн, банк санхүүгийн чиглэл чинь бүүр яг л нэг нэр томьёо нэг хэллэгтэй болчихсон шүү дээ.

Тэгэхээр ийм зүйлүүдээ ингээд бас анзаараад ингээд явчхаач энийг хасчихъя аа. Харин агуулгыг бол энэ 13 дугаар зүйлийн 2 дугаар аргачлал дотроо байгаа юм. Энийгээ хэдүүлээ мөрдөөд явъя л гэдэг саналыг хэлж байгаа юм.

Д.Цогтбаатар: Үнэн үнэ. Зарим саяын жишээлбэл Сайнзориг гишүүний хэлж байгаа юман дээр үндэслэл байна байна. Ингээд саяын томъёоллоор санал хураалт явуулъя.

Дэмжигдсэнгүй 47.4 хувиар санал дэмжигдсэнгүй ээ.

Улсын Их Хурлын гишүүн Сайнзоригийн санал дэмжигдээгүй тул Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшингийн гаргасан саналаар санал хураалт явуулъя аа.

Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.6 дахь заалтын сонирхолд нийцүүлэх зарчимд тулгуурлан гэснийг сонирхол хууль тогтоомжид нийцэх эсэхийг дүгнэн оновчтой хувилбарыг үндэслэлийн хамт санал болгох зарчмыг баримтлан гэж өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин.

Тэгэхдээ өөрийн чинь түрүүн хэлсэн юу би энд орчихсон байгаа гэж ойлгож байгаа шүү. Энэ саяын уншиж танилцуулсан томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшингийн гаргасан саналаар санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 17.1 дэх хэсгийг хасах гэснийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн... байхгүй шүү дээ. Энэ ажлын хэсгийн санал байгаа юм байна.

Тийм учраас ажлын хэсгийн саналаараа эхлээд санал хураалт явуулна.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 17.1 дэх хэсгийн “судалгаа, шинжилгээний байгууллага, судлаачаар” гэснийг “хөндлөнгийн судлаач, хуулийн этгээдээр” гэж өөрчлөх. Энэ томъёоллыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

63.2 хувиар санал дэмжигдлээ.

Сая санал дэмжигдсэн тул Энхтүвшин гишүүний саналыг уншиж танилцуулъя аа.

Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшингийн саналыг танилцуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 17.1 дэх хэсгийг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор сая санал хураах байсан. Тэгээд түрүүний санал дэмжигдээд явлаа.

14.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 18.1.3 дахь заалтыг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя аа.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалт буюу 38.1 дэх хэсгийг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

63.2 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалттай холбогдуулан бэлтгэсэн ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 38.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах 38.7 Хууль санаачлагч олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан, эс тусгасан талаарх саналын товъёгийг тайлбар үндэслэлийн хамт албан ёсны цахим хуудсандаа болон хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим системд байршуулна. Хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим систем нь энэ хуулийн 45.3-д заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн нэг бүрэлдэхүүн байна гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалттай холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя аа.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалтын 49.2 дахь хэсгийн Засгийн газраас үүрэг болгосны дагуу гэснийг хасаж 7 дахь заалт буюу 40.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

40.3 Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115, 117, 118 дугаар зүйлд заасан тайлан илтгэл нь энэ хуулийн 40.2-т заасан шаардлагыг хангасан байна гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

68.4 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан гаргасан санал байхгүй байгаа. Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан гаргасан санал байхгүй байгаа. Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

19 дүгээр санал руу оръё.

19 дүгээр санал.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төслийн 5 дугаар зүйлийн зүйлийн 15.7.1 дэх заалтын Иргэн захиргаа гэснийг 28.3.9, 28.8.6 дахь заалтын шаардлагатай бол гэснийг хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Тийм хасах гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

63.2 хувиар санал дэмжигдлээ.

20.Хуулийг дагаж мөрдөх хугацааны талаар ажлын хэсгээс гаргасан саналаар санал хураалт явуулъя аа.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төсөлд доор дурдсан агуулга бүхий зүйл нэмэх:

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал уналаа. Тийм 42.1 хувиар санал уналаа.

Төсөлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн найруулгын саналаар санал хураалт явуулъя аа. Найруулгын 3 саналтай байгаа.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн “34 дүгээр зүйлийн” гэсний өмнө ““33.5 дахь хэсгийн “33.3.3-т” гэснийг “33.3.5-т” гэж,” гэж, “39 дүгээр зүйлийн” гэсний өмнө ““38 дугаар зүйлийн 38.2, 38.4 дэх хэсгийн “40.1.3-т” гэснийг “40.1.3, 40.1.4-т” гэж, 38.9 дэх хэсгийн “12.2.23, 12.2.24-т” гэснийг “12.4-т” гэж,” гэж, мөн төсөлд **“6 дугаар зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2.17, 12.2.24 дэх заалтыг хүчингүй болсонд тооцугай.”** гэсэн зүйл нэмэх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг

Санал хураалт.

63.2 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.1.1 дэх заалтын “хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахад” гэснийг “хэрэгжүүлэхэд” гэж, 27¹.1.2 дахь заалтын “зорилтод” гэснийг “зорилт, үйлчлэх хүрээнд” гэж, 2 дугаар зүйлийн “жагсаасан” гэснийг “байрлуулсан” гэж өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг

Санал хураалт.

63.2 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 27¹.1.5 дахь заалтын “үндсэн” гэснийг, 4 дүгээр зүйлийн “эх бичвэрийн” гэсний өмнөх “англи хэл дээрх” гэснийг, 5 дугаар зүйлийн “12 дугаар зүйлийн 12.2.17, 12.2.24 дэх заалтыг,” гэснийг тус тус хасаж, төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал 52.6 хувиар дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Сайнзориг гишүүн. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулж байгаа юм аа. Яах вэ захиргааны ерөнхий хуулийг Засгийн газар анхдагч болон шинэчилснээр өргөн барьдгийг авч хаяж байгаа юм. Тэгэхдээ би яах вэ зүгээр энэ хууль тогтоомжийн хуультай холбоотой нэг зүйлийг л хэлмээр байгаа юм. Энэ Захиргааны ерөнхий хууль дээр яах вэ энэ агуулгууд орж ирэхээсээ гадна дараагийн тэр Монгол Улсын Их Хурлын тухай хууль дээр өөрчлөлт орж байгаатай холбоотой хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур гээд байгаа юм. Би яг энэ асуудалд дараа нь маргаан дагуулах вий. Хууль хэрэгжүүлэхэд саад болох вий гэдэг л зүйл байгаа. Өнөөдөр эрх олгосон заалтаар магадгүй хориглосон бараа бүтээгдэхүүний жагсаалтыг батал гээд өгдөг байхгүй юу. Тэгэхээр тэрийг бараа бүтээгдэхүүний жагсаалт гэдэг нь өөрөө материаллаг ойлголт юм.

Ийм ийм зүйлүүдийг улсын хилээр оруулахыг хориотой. Эсвэл ийм ийм зүйлүүдийг хуулиар хязгаарлалт байхгүй тэр цаг хугацаанд агнахыг хориглоно гээд байгаль орчны салбар жишээ нь. Тэгэхээр өөрөө иргэд тэр хуулиар эрх олгоод сайд буюу Засгийн газар тэрийг хэрэгжүүлэх байтал хориглосон барааны жагсаалтын энэ хууль дээр тогтоосон хязгаарлалт ерөөсөө алга аа. Зүгээр эрх олгосон заалт байна. Тэгээд сүүлдээ энэ гаалийн орж ирж байгаа бараа бүтээгдэхүүнээсээ эхлээд магадгүй өнөөдөр зүгээр энгийн жишээ авъя л даа. Хэдийгээр Үндсэн хуулиар эрүүл мэндээ хамгаалах эрхтэй боловч бүх эмийг жороор олгож байгаа юм. Жороор олгох эмийн жагсаалтыг Эрүүл мэндийн зөвлөл баталдаг. Энэ эрүүл мэндийн зөвлөлийн баталж байгаа жагсаалт нь өөрөө сүүлдээ энэ хуулиар хязгаарлалтыг тавина. Энэ эмүүдийг эмийг жороор олгох эмийн жагсаалтад хийж хязгаарлалт тавьж байгаа нь буруу гээд ийм зүйл рүүгээ ингээд явчих ийм үүд хаалга өнөөдөр нээгдчихлээ.

Тэгээд би одоо яах вэ ажлын хэсэг энийгээ сайн хэлж, ярина биз. Яг эцсийн дүндээ ийм маргаанууд гарна аа. Тэгээд их л сонин зүйл рүү орчихлоо. Би зүгээр өнөөдөр 2500 орчим эрх олгосон заалт байгаа. Үүнээс нэг Монгол Улсын Засгийн газар болон Ерөнхийлөгчийн баталдаг ийм актууд нь ХЗДХ-ийн бүртгэлгүй. Энэ тоог авангуутаа ерөөсөө журмын улс болчихлоо гээд ингээд гадуур сэвээд байгааг бүр ойлгохгүй байгаа байхгүй юу. Буруу шүү дээ. Ингэж улс төр хийж болохгүй байхгүй юу. Тэр угаасаа хүчин төгөлдөр тэр ХЗДХЯ бүртгэлгүй болоод магадгүй тэр хуульд нийцээгүй журмуудыг чинь Үндсэн хуулийн цэц нь хянаж байгаа, Захиргааны шүүх нь хянаж байгаа. Шат шатандаа ингээд явна. Ийм байдлаас болоод ингээд буруу сигнал өгөөд сүүлдээ энэ олон хуулиуд чинь сүүлдээ практик дээр мөрдөгдөхгүй болох маргаанууд үүсээд ийм эрх зүйн харилцаануудын ийм тодорхойгүй байдалд орчих вий гэдэг л ийм том болгоомжлол байна. Тэгээд энийгээ одоо тэгээд ажлын хэсэг, Байнгын хороо энэ тэр анхаарна биз дээ. Энэ зүгээр асуулт хариулт биш. Би зүгээр үг хэлж байгаа юм.

Тэгэхээр энэ ийм зүйл рүү ингээд орчихлоо. Би зүгээр протоколын хувьд хувийн хэрэг дээр үлдэг л гэж хэлж байгаа юм.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүнд тайлбараа өгье.

О.Номинчимэг: Яг энэ заалтын хувьд бол энэ Хууль тогтоомжийн хууль дээр орж байгаа өөрчлөлтийг дагаж л тэндээ нийцүүлж л орж байгаа. Тэгэхээр бид нар нэг юмыг ойлгох хэрэгтэй. Хүний эрх чөлөөг хязгаарлах гэж байгаа заавал хуулиар хязгаарлана. Тэр эрхээ тодорхой хэмжээнд рэнжтэй байдлаар захиргааны хэм хэмжээний акт гаргаж байгаа. Тэр нь хууль дээр тодорхой эх үүсвэртэй тэрэн дээр нь тэр үндсэн зарчмуудыг нь тодорхойлсон байх ёстой л гэдэг энэ зарчим тэгээд энэ чинь л ерөөсөө өдийг хүртэл сайн хэрэгжиж ирээгүй байгаа болохоор энийг улам тодотгож өгөх шаардлагатай байна гэж хууль санаачлагчийн зүгээс энэ хууль дээр оруулж ирж байгаа учраас энэ бол энэ журмаараа хуульч хүн бол бүгд л мэдэж байгаа шүү дээ. Хүний эрх эрх чөлөөг хуулиар л хязгаарлана. Энэ манай Үндсэн хууль дээр байгаа зарчим шүү дээ. Тэгээд энийгээ л ингэж оруулж өгч байгаа юм.

Тэгэхээр энэ дээр тийм таны хэлж байгаа шиг болгоомжлол бол арай тийм түвшинд очихгүй. Энэ ерөөсөө зарчмын асуудал гэдэг утгаар нь хүлээж аваасай гэж хүсэж байна.

Хоёрдугаарт тэр хийсэн энэ захиргааны хэмжээний акттай хийсэн судалгааг харахаар үнэхээр сонин дүр зураг харагдаж байна лээ. Тэгээд 2010 онд манай 681 захиргааны хэмжээний акт ХЗДХЯ-ан дээрээс байдаг бүртгэл дээр бүртгэгдэж байсан бол 2023 онд буюу 13 жилийн дараа 2357 болоод 3.5 дахин өсчихсөн юм байна. Тэгээд энд нь бол тэр Монгол Улсын Ерөнхийлөгч Засгийн газрын баталсан шийдвэрийн тоо нь ороогүй тоо юм байгаа юм. Тэгээд бид нар нэг яг хүчин төгөлдөр нийгмийн харилцааг зохицуулж байгаа 413 хууль байна. Тэндээсээ дахиад хэд юм, 8 дахин, 6 дахин их журмаар хэм хэмжээний актаар бүртгэгдсэн шүү дээ тэ. Ийм хэм хэмжээний актаар энэ нийгмийн харилцааг өөрөө зохицуулж байгаа нь ерөөсөө энэ хууль хуулийн хэм хэмжээ захиргааны хэмжээний тэнцвэрт байдлыг л алдагдуулчихсан байна гээд. Тэгээд энэ хийсэн судалгаануудыг үзэх юм бол хуулиас эх үүсвэртэй, үүсвэргүй эсвэл хуулиар эрх олгоод журам батална гэчихсэн байгаа боловч батлаагүй тиймээ тэгээд төрийн захиргааны байгууллагууд нь журмаа батлаагүй болохоор энэ асуудлыг шийдэхгүй гээд гацаадаг гээд олон асуудлууд энд байгаа учраас энэ хуулиар бол яг Хууль тогтоомжийн хуулиар энийгээ л жоохон цэгцэлж оръё гэсэн үзэл баримтлал амин сүнс нь энд байгаа л гэдгийг хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Одоо санал хураалт руугаа оръё.

Ингээд Сайнзориг тодруул тодруул. Сайнзоригийн микрофоныг өгье.

П.Сайнзориг: Ийм юмаа, Засгийн газрын тогтоолоор явж байсан харилцааг 2016 онд Захиргааны ерөнхий хуулийг батлаад 2017 оны 7 сарын 1-ээс хэрэгжүүлээд наадах чинь цэгцрэхгүй байсан юмнуудыг цэгцлээд авсан үр дүн байхгүй юу.

Хоёрдугаарт яах вэ зүгээр би буруутгаж байгаа юм биш. Парламент баталсан хууль. Юу вэ гэхээр Хог, хаягдлын тухай хууль, Газрын тухай хууль, дээрээс нь

Малын хөлийн татварын тухай хууль гэх зэрэг ТХГН-ийн хууль гээд. Энэ хуулиуд чинь 330 суманд эрх олгочихсон байхгүй юу. Тэгээд наад журмын тоо чинь зүгээр 2 мянга хэдэн зуу руу харагдаад байгаа болохоос биш яг нарийн ярих юм бол бас тийм том тоо биш. Бид нар социалист эрх зүйн тогтолцоотой байж байхдаа нам төрийн бараг 3 мянган шийдвэр дагадаг байсан юм байна лээ.

Өнөөдөр харилцаа ийм том болчихоод байхад та нар бодоорой. Тэгэхээр энийгээ зөв мессежүүдийг нь өгөхгүй бол нэг их журмын улс болчихсон юм шиг журмыг дагаж мөрдөхгүй гэдэг ийм мессеж би ерөөсөө бид хэдийн асуудал байхгүй юу. Хууль тогтоогч магадгүй аль болохоор юмнуудыг хуульдаа тусгаад явах тэр л ажлаа хийх сайн хийх ёстой байсан болохоос биш журам гаргадаг энэ эрхээр буруутгаж болохгүй. Тэгэхдээ энэ хуулиар юу ч засагдахгүй. Гол үр дагавар юу байсан бэ гэхээр тэр хог хаягдал, газрын төлбөр, малын хөлийн татвар гээд 330. Энэ чинь ингээд зүгээр гуравхан хуулийг дурдахад мянган шийдвэр байхгүй юу даа. Мянган хууль, мянган захиргааны хэмжээний хаагчийн гуравхан хуулийн үйлчлэл.

Тэгэхээр та нар ингээд статистикийг гаргаж худлаа ингэж хүмүүст ингэж шидэж байгаа боловч орон нутгийн эрхийг булааж байгаа юм 1 дүгээрт, орон нутаг юмаа шийд гэсэн эрхийг энэний цаана байхгүй болгоё гэдэг концепц явж байна.

Хоёрдугаарт зүгээр л бодитой тоог нь хэл л дээ. Тэгэхээр хэдүүлээ ийм зүйлүүдийг ингэж бас нэг зөв мессежүүдийг нь зөв өнцгүүдийг нь өгөхгүй бол 2500 журам ерөөсөө л ингэчихсэн юм шиг ийм юм байж болохгүй байхгүй юу. Би зүгээр ийм бодитойг нь л хэлье.

Д.Цогтбаатар: Саналаа хураая аа. Энд зүгээр энэ хуулийг анх судлаачид над дээр оруулж ирэхэд ингэсэн шүү. Яг одоо миний байр суурь журамгүй улс гэж байдаггүй юм. Журмууд бүх газар байгаа. Тэгэхээр тэр журмыг байхгүй болгох гэж ерөөсөө хийгээгүй. Журмыг хуулийн үндэслэлтэй болгох гэж л хийсэн. Хууль тогтоогчид тэгэхлээр хариуцлагатай л хандах ёстой. Цаанаа ямар үр дагавар гарч болзошгүй вэ гэдгийг тооцож хууль гаргаж байгаа юм бол хууль тогтоогчид нэн тэргүүнд өөрсдөө хариуцлагатай байх ёстой тэр журмын нүх сүвээ өөрөө гаргаж өгч байх ёстой л гэдэг юугаар орж ирж байгаа шүү дээ. Би түрүүн ингээд уншаад танилцуулчихсан байгаа.

Тэгэхээр миний уншиж танилцуулсан томъёоллоор санал хураалтыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Горим Соронзонболд гишүүн горимын санал гаргая.

Л.Соронзонболд: Энэ сая нөгөө нэг санал өгөх юу маань дэлгэцэд гарч ирсэнгүй. Тэгэхээр саналыг дахиж хураалгах саналтай байна.

Д.Цогтбаатар: Саяын горимын саналын дагуу сая хураагдсан санал хураалтыг хүчингүйд тооцъё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. Санал хураалтыг түр цуцалъя энэ юу гарахгүй байна. Ингээ ахиад тэгвэл санал хураалтдаа бэлдье. Бэлдье гэдэг чинь бүгдээрээ хуруугаа

уншуулна гэсэн үг биз дээ. Минийх болохгүй байна. Туршилтын санал хураалт нэг явуулаадахъя.

Санал хураалт.

Одоо орж байна уу? Гишүүдийнх. Минийх байхгүй. Минийх өөрийнх байхгүй байна. Техникийн хүмүүс ирээрэй.

Туршилтын нэг санал хураалт явуулаад үзье дээ.

Санал хураалт. Зүгээр байна.

Тийм учраас түрүүн уншиж танилцуулснаар санал хураалт.

Түрүүний саналыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ. Ингэснээр түрүүний санал хүчингүй болсон.

Санал хураалт.

Түрүүний саналыг чинь би зарлачхаад шууд хүчингүй санал зогсооё гээд зогсоочихсон байхгүй юу. Одоо ингээд түрүүн уншиж танилцуулсан саналын томъёоллоор санал хураалтаа явуулъя.

Санал хураалт.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Ажлын хэсгийн санал.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан гаргасан санал байхгүй байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулан өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би зүгээр энэ хууль санаачлах хүрээ хязгаарыг Үндсэн хуульд яах вэ оруулаад 2019 онд. Тэгээд энэ Улсын Их Хурлын хууль дээр хийчихсэн байгааг л жоохон ойлгохгүй байгаа юм. Улсын Их Хурлын тухай хууль маань Улсын

Их Хурлын үйл ажиллагаа зохион байгуулалтыг шийддэг болохоос биш Монгол Улсын Засгийн газар Ерөнхийлөгчийн хууль санаачлах хүрээ хязгаарыг шийддэг зүйл биш л дээ. Тэгэхдээ яах вэ зүгээр энэ удаад ингээд найруулга жоохон гишүүдэд хууль санаачлах хүрээ хязгаарыг жоохон нэмэгдүүлж байгаа юм байна, ойлгож байгаа. Ер нь зүгээр цаашдаа уг асуудлын заалт нь хууль тогтоомжийн хууль дээрээ орох ёстой юм гэдэг зүйлийг хэлмээр байгаа юм 1 дүгээрт.

Хоёрдугаарт энэ Засгийн газар зөвхөн санаачилга хууль дээр бол нийгмийн даатгалын болоод энэ халамжийн хуулиудаа уг нь нэмчихмээр байгаа юм аа. Тэгээд бид хэд ингээд сонгууль дөхөөд ирэхээр жоохон энийг барьж авч явдаг нэг хэдэн хүмүүс гараад ирдэг юм. Тэгээд хууль батлагдахгүй байх нь бүүр сайн гэдэг тэгээд тэрийгээ яриад л яваад байдаг. Ийм байдлаар нөгөө олон нийтэд аймаар тийм хүлээлт үүсгэдэг халамж нэмэх гэж байгаа юм шиг. Эргээд энэ НДШ нөгөө тооцох аргачлалаасаа эхлээд бууруулах гэж байгаа ч юм шиг. Ингээд ийм ийм улс нөхцөл байдлууд түлхээд байдаг. Тэгэхээр энийг уг нь шинэчилсэн болон анхдагч хуулиар нь Улсын Их Хурлын гишүүд санаачлах нь зохимжгүй юм байгаа юм. Яах вэ зүгээр нэмэлт, өөрчлөлтийг хязгаарлаж болохгүй л дээ.

Тэгэхээр ер нь энийг нэг зарчмын хувьд хэлчихмээр байгаа юм. Тэгээд би яах вэ зүгээр энэ хуулийн гол асуудал юу вэ гэхээрээ Хууль тогтоомжийн хууль маань өөрөө эргээд Үндсэн хуулийн эх сурвалжийн хувьд жоохон дутагдаад байгаа юм аа. Өөрөөр хэлэх юм бол хууль тогтоомжийн ангилал, төрөл, түүнийг батлах квотыг хууль тогтоомжийн хуулиар шийднэ гэдэг Үндсэн хууль дээр ганц заалт байсан бол бид нар энэ хуулиудаа зөв ангилаад түүнийг батлах квотоороо энэ хуулийн тогтвортой байдал боловсруулалтын шаардлагуудыг өндөрсгөж болох юм аа.

Тийм ч учраас яах вэ зүгээр цаашдаа энэ Хууль зүйн байнгын хороо мэргэжлийн Байнгын хороо байгаа учраас энэ асуудлыг бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэзээ нэгэн цагт хийгдэх байх. Зүгээр энэ парламент биш байж магадгүй. Тэр цагт энэ хууль тогтоомжийг зөв ангилаад тэрийгээ батлах квотыг зөв болгочих юм бол Монгол Улсын хууль зүйн системчлэл болоод тогтвортой байдал энэ бүх зүйлүүд шийдэгдэх юм байгаа юм аа.

Өнөөдөр бүх зүйлүүдийг ингээд нэгхэн уутанд чихэж оруулчхаад бүгд дээр нь ийм ижил шаардлага тавиад яваад байхаар болохгүй байгаа. Бусад оронд бол органик хуулийг парламентад сонгосон гишүүдийн 66 хувиар буюу манайхаар бол 84 гишүүнээр баталдаг байхгүй юу, 64-өөр ч биш. Ингэж байж харин бусад хуулиудаа ингээд Байнгын сайжруулалт хийгээд явдаг ийм л зүйл байгаа. Тэгэхээр энийгээ би зүгээр ингээд протоколын хувьд хэлье тэгээд ер нь бол энэ Улсын Их Хурлын тухай хууль дээр байх эд биш. Тэгэхдээ энийг нэгэнт байгаа заалт учраас сайжруулж байгаа гэж ойлгож байгаа. Эндээс Захиргааны ерөнхий хуулийг авч хаяж байгаа зүгээр үндэслэл шалтгаанаа нэг тайлбарлачхаач.

Ер нь яах юм Захиргааны ерөнхий хуулийг ч юм уу өргөн барих гээд байгаа юм уу. Өргөн барих гээд тэгсэн чинь энэ заалт саад болоод шинэчилсэн найруулгыг өргөн барих гээд байгаа юм уу? Ийм санаа оноо байгаа юм уу? Ямар учраас Захиргааны ерөнхий хуулийг Засгийн газар зөвхөн өргөн барьдаг байсныг больё.

Д.Цогтбаатар: Сая бол энэ нөгөө 1 дүгээр зүйлтэй холбоотой санал асуулт байна уу гэж асуусан шүү дээ. Тэгэхээр одоо энэ дээр та бол энэнээс өөр юм асуугаад яваад байна шүү дээ. Номинчимэг гишүүн яах вэ тайлбарлах уу?

О.Номинчимэг: Гараагүй шүү дээ ажлын хэсгээс тиймээ. Энэ саяын Сайнзориг гишүүний дурдсан асуудал дээр бол ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй санал ерөөсөө гараагүй байгаа. Бид нар энэ дээр Улсын Их Хурлын тухай хуульд оруулах хууль дээр бол энэ өмнөх хууль тогтоомжийн их хуулийнх нь хэрэгжих хугацаа анх орж ирэхдээ ердийн хугацаагаар байсан. Тэгээд яах вэ энэ хуулийг илүү 4, 5 сардаа хэлэлцээд гарах болов уу? Тэгэхээр хууль санаачилж байгаа гишүүддээ Засгийн газарт энийг хэрэгжүүлэхэд хугацаа шаардлагатай юм чинь хугацааг нь жоохон тавиу тавьж өгье өө гээд 8 сарын 1 гэдэг хугацаа байсан. Гэхдээ одоо ингээд 6 сар гарчихлаа.

Дээр нь Хууль тогтоомжийн хуулийн хэрэгжих хугацаа маань өөрөө түрүүний санал хураалт дээр унаад энгийн журмаар явах ёстой гэсэн саналууд гарсан учраас энэтэйгээ ч гэсэн нийцүүлээд Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн энэ хэрэгжих хугацааг нь бол нийцүүлсэн нь дээр учраас энэ саналыгаа татаж аваад юу яая энгийн журмаар тэгвэл үйлчлэх байдлаар хуульдаа өөрчлөлт оруулъя гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Цаашаа явъя үргэлжлүүлээд. Тийм ажлын хэсэг хөндөөгүй асуудал тийм.

Ариунхур дарга хариулах уу? Зарчмын санал гараагүй байгаа. Тийм зарчмын ерөөсөө санал гараагүй болохлоор Ариунхур дарга хариулаад явчих. 8 дугаар микрофон.

Ч.Дондогмаа: Сайнзориг гишүүний асуултад хариулъя аа. Гишүүдийн Улсын Их Хурлын гишүүдийн хууль санаачлах эрхийг хэд хэдэн зохицуулалтаар хязгаарласан байна гэсэн үндэслэлээр энэ гишүүдийг захиргааны ерөнхий хуулийг санаачлах эрхийг нэмэгдүүлэх хүрээнд гарсан саналын хүрээнд энэ зохицуулалт орж ирсэн байгаа. Захиргааны ерөнхий хуулийг гишүүд санаачлах боломжтой болгоё гэсэн санал гарч. Энэ дээр Их Хурлын гишүүд санаачлах гээд байгаа ч юм уу тийм зохицуулалт байхгүй. Энэ нөгөө Хууль тогтоомжийн хуулийн хүрээнд судалгаа хийж байхад гарч ирсэн саналын хүрээнд нэмэгдүүлж тусгасан заалт.

Д.Цогтбаатар: Яах вэ би энэ дээр нэг зүйл нэмээд хэлчихье. Яг лав л төсөвтэй холбоотойгоор одоо ингээд агуу хууль бид нар яриад л суугаад байдаг. Би та нарт яг төсөв дээр өнөөдрийн манай төсвийн проблемыг хэлэх үү? Жишээлбэл Төсвийн тодотголын тухай хууль өнөөдөр байж байгаа хууль шүү дээ. Төсвийн тодотголын хууль дээр Их Хурлын гишүүд санал гаргах өнөөдөр эрхгүй байгаа хязгаарлачихсан. Яагаад гэвэл Төсвийн тодотголын хуулийг төсвийн хууль гээд үзчихсэн байхгүй юу. Тэгтэл төсвийн тодотгол бол цэвэр улс төрийн процесс байхгүй юу. Тэгэхээр төсөв гээд үзчихсэн болохлоор бид нар санаачлаад би жишээлбэл энэ дээр санаачлах гээд чадахгүй байгаа байхгүй юу. Тэгсэн чинь төсвийн тодотголыг оруулж ирэхэд гэнэт Засгийн газар аягүй их зардлаа нэмэгдүүлье гээд ороод ирвэл энэ цэвэр улс төрийн асуудал. Хэлэлцэх үү, эсэх үү гэдэг чинь хамгийн чухал улс төрийн асуудал байгаа байхгүй юу. Би хэлэлцэхгүй гэвэл яах юм. Тэгсэн тийм юм байхгүй. Энэ чинь төсөв учраас шууд нөгөө 2 дугаар юунаасаа хэлэлцүүлээд явчихна. Түүнээс хэлэлцэх эсэх асуудал байхгүй байгаад байгаа. Гэх мэт. Тэгэхээр ингээд төсөвтэй холбоотой гишүүдийн нээрээ зайлшгүй байх ёстой эрхийг хязгаарлачихсан юмнууд байгаад байгаа тэрийг нь л бид нар

нэмж өгье гэж байгаа. Гишүүд тэгээд өөрсдөө идэвхтэйгээр ашиглавал тэр биз. Ашиглахгүй бол тэр л биз.

Нөхцөл байдал бол гишүүдийн тэр эрхээ л тэлж өгье гэж байгаа юм. Угаасаа ч Үндсэн хуулиараа 3 л субъект хууль санаачлах эрхтэй байгаад байгаа шүү дээ. Тэр нь бол Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгч, Засгийн газар гэсэн 3 субъект л байгаа.

Ингээд цаашаа үргэлжлүүлье ээ. Хуулийг дагаж мөрдөх хугацааны талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төсөлд дор дурдсан агуулга бүхий зүйл нэмэх:

1 дүгээр юун дээр тэгсэн тэгсэн. Тэгвэл одоо саяын миний уншиж танилцуулсан энэ юуг бол ажлын хэсэг татаад авчихсан. Цаашаа тэгвэл үргэлжлүүлээд явъя. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Яах вэ энэ асуудлыг Засгийн газар хийдэг л дээ, хийдэг. Тэгээд бүртгүүлэхгүйгээр журам дагаж мөрдүүлж байна уу гэдгийг Хууль зүй, дотоод хэргийн яам хянадаг эд биш. Тухайн харилцаанд оролцож байгаа этгээд, өртсөн этгээд эсвэл дээд шатны байгууллагын хяналт шалгалтаар ч юм уу явдаг. Ингэж шүүрдэгдээд хийгээд, тэрнээс дагаж мөрдүүлсний үр дагаврыг тэр мөрдүүлсэн, баталсан этгээд хариуцдаг ийм хуультай. Тэгээд энийг бол жил болгон мониторинг хийгээд Засгийн газарт танилцуулаад Засгийн газраас шаардлагатай, Засгийн газраас доошоо чиглэл өгч болох байгууллагуудын хууль зөрчсөн шийдвэрүүдийг хүчингүй болгодог. ИТХ-ын шийдвэрүүдээр зөвлөмж хүргүүлж энийгээ засаж ир гэдэг ийм л процесстой яваа. Би зүгээр 2017 оны Захиргааны ерөнхий хуулиас маш том дэвшлийг авчирсан. Бүх зүйл хяналтад ороод цэгцрэх тал руугаа явж байгаа байхгүй юу.

Хууль зүй, дотоод хэргийн яам ч гэсэн энэ дээрээ нэгж байгуулж ажилласан, ач холбогдол өгч ажилласан. Энийг нэг үеэ бодвол нэлээн тийм цэгцрээд ирж байгаа юм. Хуучин бол хуулийг маш ерөнхий гаргачхаад сайд нь дэлгэрүүлээд нарийвчилсан хууль хэрэгжүүлэх журам гээд л гаргачихдаг байсан. Энийг яг 180 градусын эсрэг талд оруулсан хууль маань Захиргааны ерөнхий хууль, энэ хууль тогтоомжийн хууль байсан юм аа.

Би зүгээр энэ хуулиа зөв хэрэгжүүлээд явах.

Хоёрдугаарт би зүгээр олон нийтийн нэг зүйлийг хэлж байгаа юм. Би яагаад гэхээр сая бас ХЗДХ-ийн сайд байсан хүн би бүртгэсэн журмуудыг шууд хүчингүй болгосон юм, болгож байгаа. Тэрнээс дагаж мөрдөж байгаа журмуудаас үүссэн хохирлоо нэхэмжлээрэй энэ тэр гээд СЗХ-ны журмыг дураараа хүчингүй болгосон байхгүй юу. Хууль зүйн сайдад ийм эрх байхгүй. Гэтэл одоо яг энэ хуулиар бас энэ журмуудыг аймаар багасгачхаж байгаа ч юм уу ийм зүйлүүд яриад байгаа юм. Манай Номоогийн хэлж байгаа тэр гагцхүү хуулиар зохицуулах асуудлыг эрх олгосон заалтаар хийж болохгүй гэхээр ерөөсөө Үндсэн хууль дээр хоёрхон хууль

байгаа байхгүй юу. Харьяатын хууль нэг нь юу билээ байз. Тэр харьяатын хуулиар 4, тавхан журам л гарна. 4 тавхан журмыг цөөлөхийн тулд ингэж тайлбаруудыг хэлж байгааг би ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Тэгэхдээ энэ яах вэ тогтоол гаргээ.

Ер нь бол Засгийн газрын хийдэг юм байгаа. Бид харин Засгийн газраасаа яг энэ асуудлаар юу хийсэн юм бэ гэдгийг зүгээр шаардаад сонсчихын оронд дахин дахин давтаж Улсын Их Хурал өөрөө нэг ийм ажил хийж байгаа юм шиг дүр оруулж ингэж чиглэл өгөөд байгааг ойлгохгүй байгаа юм.

Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг аваад ир гээд л хэл л дээ. Захиргааны ерөнхий хуулийн захиргааны хэмжээний актын хяналт бүртгэлтэй холбоотой хэсгийн хэрэгжилтийг Улсын Их Хурал дээр сонсьё гээд манай Хууль зүйн байнгын хороо хэлье л дээ. Бид өөрсдөө ажлаа ингээд хийхгүй байж байж ийм ингээд нэг ийм чиглэл өгөөд ингээд хийдэг ажлуудыг давтаж өгөөд одоо нэг сүр бараатай журмуудыг цөөлөх гэж байна. Журмуудыг хяналтад оруулах гэж байна. Ингэж наад улс төрийн пи ар хийдгээ боль.

Д.Цогтбаатар: Тогтоолын төсөлтэй холбогдуулан ажлын хэсгийн бэлтгэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Тогтоолын төслийн 1 дүгээр заалтын 2 дахь дэд заалтын холбогдох хуулиудын төслийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан гэснийг судалгаа хийж холбогдох хуулиудын төслийг 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор Улсын Их Хуралд гэж өөрчилж, энэ заалтад дор дурдсан агуулгатай 4 дэх заалт нэмэх:

4.Хууль санаачлагчид мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий төрийн холбогдох байгууллагын албан хаагчдыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан холбогдох аргачлал, арга зүйгээр хангах, чадавхжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж хэрэгжүүлэх гэснийг дэмжье гэсэн. Томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

“Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын удирдлагад даалгасугай:

1/хуулиар тусгайлан эрх олгогдоогүй бөгөөд нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг хүчингүй болгох;

2/хуульд заасны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;

3/эрх зүйн зохицуулалтын ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, хууль тогтоомжтой зөрчилдсөн, эрх олгосон хуулийн заалт нь хүчингүй болсон, өөрчлөгдсөн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, хуульд нийцүүлэн шинэчлэн батлах;

4/эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг, сонирхлын зөрчил, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн шинжтэй дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөх.” гэснийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал гаргасан ажлын хэсэг.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмэх:

“6.Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг нийтийн эрх зүйн этгээдэд зөвлөсүгэй.” гэснийг дэмж дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг танилцуулна аа.

12.18 цаг

Дараагийн асуудалдаа оръё. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах асуудлыг хэлэлцье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 106.1-д Улсын дээд шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигчийн танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд ирүүлнэ гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын Их Хуралд 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэр дэвшигч Ц.Очийг танилцуулах тухай 01/983 нэр дэвшигч Э.Золзаяаг танилцуулах тухай 01/984 тоот танилцуулга ирүүлснийг уг хуулийн 106.2-т энэ

хуулийн 106.1-д заасан танилцуулгыг ирүүлснээс хойш 7 хоногийн дотор чуулганы чөлөөт цагт ирүүлсэн бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор нэр дэвшигчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж заасны дагуу хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Албан тушаалтнуудын нэрс, ажлын хэсэг.

Мөнгөнцэцэг-Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Ц.Оч-Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Э.Золзаяа-Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч. Ийм 3 хүнтэй бүрэлдэхүүн байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцууллаа.

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Нямсүрэнгийн Мөнгөнцэцэг танилцуулна аа.

Мөнгөнцэцэг даргын микрофоныг өгье. 4 дүгээр микрофон.

Н.Мөнгөнцэцэг: Та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Цогийн Очийн танилцуулгыг хийе.

Товч намтар Нэр дэвшигч Цогийн Оч нь 1978 онд Улаанбаатар хотод төрсөн, 47 настай, эрэгтэй, ам бүл 6.

1986-1996 онд нийслэлийн 18 дугаар дунд сургууль, 1996-2001 онд Улаанбаатар Эрдэм дээд сургууль эрх зүйч бакалавр, 2009-өөс 2021 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хууль зүйн ухааны магистрын зэрэг тус тус хамгаалсан. Тэрээр 2001-2002 онд Энигма ХХКомпанид хуульч, 2002-оос 2006 онд Монгол Улсын дээд шүүхэд шүүгчийн туслах, 2006-аас 2008 онд БГД-ийн шүүхийн шүүгч, 2008-аас 12 онд Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгч, 2012-оос 2013 онд Хэнтий аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч, 2013-2015 онд Эрүүгийн хэргийн давж заалдах шатын 10 дугаар шүүхийн шүүгч, 2015 оноос Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгчээр ажиллаж байна аа.

Нэр дэвшигч нь төрийн албанд 24 жил, шүүгчээр 19 жил 2 сар. Үүнээс давж заалдах шатын шүүхэд 12 жил 5 сар ажиллаж байна.

Хоёрт хуульд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан байдлын талаар танилцуулъя.

Нэр дэвшигч Оч нь Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан хяналтын шатын шүүхийн шүүгчид тавих болзол шаардлагыг дараах байдлаар хангаж байна аа.

Нэгд, Хууль зүйн дээд боловсролтой байх.

Нэр дэвшигч Оч нь 1996-аас 2001 онд Улаанбаатар эрдэм дээд сургууль, эрх зүйч бакалавр, 2009-өөс 2021 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль Хууль зүйн ухааны ухааны магистр зэргийг хамгаалсан.

35 нас хүрсэн Монгол Улсын иргэн байх.

Нэр дэвшигч Оч нь 1978 оны 12 сарын 15-ны өдөр төрсөн, 47 настай Монгол Улсын иргэн.

Гуравт, Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх.

Нэр дэвшигч Оч нь гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаагүй тухай ЦЕГ-ын холбогдох албаны 2025 оны 2 сарын 25-ны өдрийн 10/524 дүгээр албан бичиг мөн эрүүгийн хариуцлага хүлээгээгүй тухай E Mongolia.mn цахим мэдээллийн сангийн 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн лавлагаагаар тус тус тодорхойлогдоно. Шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй тухай Монгол УЕПГ-ын 2025 оны 5 сарын 5-ны өдрийн 4/2142 дугаар албан бичгээр лавлагаа ирүүлсэн. Шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэц, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчилгээ, эмчийн магадалгаатай байх, эрүүл мэнд сэтгэцийн талаар холбогдох эрүүл мэндийн байгууллагын 2025 оны 2 сарын 11-ний өдрийн дүгнэлтээр эрүүл, тэнцэнэ гэж дүгнэсэн.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй, Монголын Хуульчдын Холбооноос 2014 оны 7 сарын 7-ны өдөр Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн 2107 дугаартай гэрчилгээг шинэчлэн олгосон.

Нэр дэвшигчийн хуульчийн гэрчилгээ хүчинтэй тухай Монголын Хуульчдын Холбооны 2025 оны 2 сарын 28-ны өдрийн 2/203 дугаар албан бичгээр лавлагаа ирүүлсэн шүүгчээр ажиллах мэдлэг, чадвар, ёс зүйтэй байх нэр дэвшигч Оч нь хууль зүйн мэдлэг чадварын шалгалтад 50.71 оноо, мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад 26.52 оноо авч хяналтын шатын шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн.

Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх тухай.

Нэр дэвшигч Оч нь шүүгчээр нийт 19 жил 2 сар ажилласан, 2006-2008 онд БГД-ийн шүүхийн шүүгч, 2008-аас 2012 онд Дархан-Уул аймаг дахь сум дундын ерөнхий шүүгч, 2012-оос 2013 онд Хэнтий аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч, 2013-аас 2015 онд Эрүүгийн хэргийн давж заалдах шатын 10 дугаар шүүхийн шүүгч, 2015 оноос Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгчээр ажиллаж байгаа туршлагатай.

Сүүлийн 6 жил улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй байх.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 72 дугаар зарлигаар Шүүгчийн албан тушаалд томилогдож өнөөдрийг хүртэл ажиллаж байгаа тул сүүлийн 6 жилийн хугацаанд аливаа улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй болно оо.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 3-ны 2-оос доошгүй нь шүүгч байх, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 3-ны 2-оос доошгүй нь энэ хуулийн 31.4.1-д заасан шүүгч байна гэж заасан.

Нэр дэвшигч Оч нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан тул шаардлагыг хангаж байна аа.

Сонгон шалгаруулалтад тэнцсэн байдал.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасны дагуу шүүгчид нэр дэвшигчдээс авсан шалгалтад Оч нь хууль зүйн мэдлэг чадварын шалгалтад 50.71 оноо, мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад 26.52 оноо, нийт 77.23 оноо авч тэнцсэн.

Нэгдүгээрт эрэмбэлэгдсэнийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 5 сарын 23-ны өдрийн 117 дугаар тогтоолоор баталсан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 05 сарын 26-ны өдрийн хуралдаанаар бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журмын 9.4-д заасныг баримтлан хяналтын шатын шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалт 1 дүгээрт эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Цогийн Очийг Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчээр томилуулах саналыг Монгол Улсын Их Хуралд ийнхүү танилцуулж байна аа.

Мөн 2-т эрэмбэлэгдсэн Монгол Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Энэбишийн Золзаяагийн танилцуулгыг хийе.

Нэр дэвшигч Энэбишийн Золзаяа нь 1970 онд Улаанбаатар хотод төрсөн, 55 настай, эмэгтэй. Ам бүл-4, 1978-аас 1988 онд Нийслэлийн 18 дугаар сургууль, 1988-аас 1994 онд ОХУ-ын Москва хотын Нийтийн ахуйн үйлчилгээний улсын академи, инженер, техникийн ухааны магистр, 1996-аас 1999 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургууль, эрх зүйч бакалавр, 2009-өөс 2016 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль Хууль зүйн ухааны магистрын зэрэг тус тус хамгаалсан. Тэрээр 1999-өөс 2004 онд Нийслэлийн шүүхэд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, 2004-өөс 2006 онд Баянзүрх дүүрэг шүүхийн шүүгч, 2006-аас 2013 онд СБД-ийн шүүхийн шүүгч, 2013-аас 2014 онд Дүүргийн иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгч, 2014-өөс 2015 онд Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шатны шүүгч, 2015 оноос Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгчээр ажиллаж байна аа.

Нэр дэвшигч нь төрийн албанд 26 жил 4 сар, шүүгчээр 20 жил 7 сар, үүнээс давж заалдах шатын шүүхэд 11 жил ажиллаж байна аа.

Хуульд заасан шалгуур хангасан байдлын талаар.

Нэр дэвшигч Золзаяа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан хяналтын шатын шүүхийн шүүгчид тавих болзол шаардлагыг дараах байдлаар тавих шаардлагыг дараах байдлаар хангаж байна.

Нэгд, Хууль зүйн дээд боловсролтой байх.

Золзаяа нэр дэвшигч нь 1996-аас 1999 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль, эрх зүйч бакалавр, 2009-өөс 2016 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан.

35 нас хүрсэн Монгол Улсын иргэн байх тухайд Нэр дэвшигч Золзаяа нь 1970 оны 6 сарын 30-ны өдөр төрсөн 55 настай, Монгол Улсын иргэн.

Нэр дэвшигч Золзаяа нь гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаагүй тухай ЦЕГ-ын холбогдох албаны 2025 оны 2 сарын 25-ны өдрийн 10/524 албан бичиг, мөн эрүүгийн хариуцлага хүлээгээгүй тухай E Mongolia.mn цахим мэдээллийн сангийн 2025 оны 2 сарын 12-ны өдрийн лавлагаагаар тус тус тодорхойлогдоно.

Шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй байх тухай.

Монгол УЕПГ-ын 2025 оны 5 сарын 15-ны өдрийн 4/2349 дүгээр албан бичгээр лавлагаа бол ирүүлсэн.

Нэр дэвшигч шүүгчээр ажиллахад харшлах өвчин сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадалгаатай байх.

Нэр дэвшигч эрүүл мэнд сэтгэцийн талаар холбогдох эрүүл мэндийн байгууллагын 2025 оны 2 сарын 5-ны өдрийн дүгнэлтээр эрүүл, тэнцэнэ гэж дүгнэсэн.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх талаар.

Нэр дэвшигч нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй. Монголын Хуульчдын Холбооноос 2014 оны 7 сарын 7-ны өдөр Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн 2194 дугаартай гэрчилгээг шинэчлэн олгосон.

Нэр дэвшигчийн хуульчийн гэрчилгээ хүчинтэй тухай Монголын Хуульчдын Холбооны 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 2/203 дугаар албан бичгээр лавлагаа ирүүлсэн.

Шүүгчээр ажиллах мэдлэг, чадвар, ёс зүйтэй байх.

Нэр дэвшигч Золзаяа нь хууль зүйн мэдлэг чадварын шалгалтад 54.54 оноо, мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад 22.17 авч хяналтын шатны шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн.

Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх тухайд.

Нэр дэвшигч Золзаяа шүүгчээр нийт 20 жил 7 сар ажилласан. 2004-өөс 2006 онд БЗД-ийн шүүхийн шүүгч, 2006-аас 2013 онд СБД-ийн шүүхийн шүүгч, 2013 онд Дүүргийн иргэний хэргийн анхан шатын 1 дүгээр шүүхийн шүүгч, 2014-2015 онд Иргэний хэргийн давж заалдах шатын 10 дугаар шатны шүүхийн шүүгч, 2015 оноос Нийслэлийн иргэний давж заалдах шатын шүүхийн шүүгчээр ажиллаж байгаа туршлагатай байна.

Сүүлийн 6 жил улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй талаар.

Нэр дэвшигч нь Золзаяа нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 156 дугаар зарлигаар шүүгчийн албан тушаалд томилогдож өнөөдрийг хүртэл ажиллаж байгаа тул сүүлийн 6 жилийн хугацаанд аливаа улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй болно.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 3/2-оос доошгүй нь шүүгч байх гэсэн шаардлагын тухайд.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 3-ны 2-оос доошгүй нь энэ хуулийн 31.4.1-д заасан шүүгч байна гэж заасан. Нэр дэвшигч Золзаяа нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан тул дээрх шаардлагыг хангаж байна.

Сонгон шалгаруулалтад тэнцсэн байдал.

Нэр дэвшигч Золзаяа нь Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9 дэх хэсэг Монгол Улс Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 6 сарын 14-ний өдрийн 173 дугаар тогтоолд заасны дагуу хүчинтэй байгаа 76.71 үнэлгээгээр 2 дугаарт эрэмбэлэгдсэнийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 5 сарын 23-ны өдрийн 117 дугаар тогтоолоор баталсан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 5 сарын 26-ны өдрийн хуралдаанд бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журмын 9.4-д заасныг баримтлан хяналтын шатын шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад 2 дугаарт эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Энэбишийн Золзаяаг Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчээр томилуулах саналыг ийнхүү Монгол Улсын Их Хуралд танилцуулж байна аа.

Танилцуулгыг хийж дууслаа. Баярлалаа.

Б.Энхбаяр: Мөнгөнцэцэг даргад баярлалаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон нэр дэвшигчдээс асуух асуулттай гишүүн нараасаа өгнө үү. Асуулт үг тусдаа. Асуулт Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн асуултаа асууя. Аан Эрдэнэболд гишүүнээс асуултаа асууя.

Эрдэнэболд гишүүн алга байна. Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Яах вэ ер нь бол ямар ард түмэн байна тийм төр засаг байдаг л гэж байгаа юм. Энэ ч яах вэ энэ Улсын Их Хуралтай л холбоотой л доо. Шүүх засаглал бол тусдаа. 3 засаглал бий. Шүүх засаглал байна, хараат бус хуулийнхаа дагуу байж чадаж байгаа юу? Би энийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс л асуумаар байна л даа. Шүүхийн ерөнхий зөвлөл хуульд заасны дагуу хараат бус байхыг хариуцдаг шүүгч нарынхаа. Энэ талаар та бүхэн ямар ажил төрөл хийж байгаа вэ? Хэр зэрэг үр дүнтэй байгаа вэ? Ялангуяа сүүлийн үед шүүгч нарыг бас хараат байна ч гэдэг юм уу эсвэл хараат болгохын тулд янз бүрийн байдлаар нэр ус нь дурдагдсан, дурдаж байгаа гүйцэтгэх засаглалаас нэг тиймэрхүү хандлагууд гардаг аа. Шүүгч нар л болохгүй байгаа юм шиг. Болохгүй юм ч байгаа байх. Яаж яаж нөлөөлөөд байна вэ? Гүйцэтгэх засаглалын мэдэлд бол АТГ байгаа. АТГ бол шүүгч нарыг шалгадаг ийм байгууллага байх гэж ойлгоод байна.

Нөгөө талаар бол Сахилгын хороо гэж бий. Сахилгын хороо чинь 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөр өөрчлөлт ороод 2021 оноос эхлээд байгуулагдаад ингээд ажиллаж байгаа байх аа. Тэнд бол 9 хүн байгаа. 5 нь бол албан тушаалтнуудаас буюу Улсын Их Хурлаас томилогдоод очиж байгаа. 4 нь шүүгч байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөл бол тав таваараа байгаа байх, 2 талаас гэж ойлгож байна. Тэр хууль маань хэрэгжээд эхэлснээс Сахилгын хороо бол Үндсэн хуульд заасан ийм байгууллага. Гэхдээ энэ байгууллага маань ажиллаад 5 жил болж байна аа. Энэ хооронд үнэлэлт юм хийсэн юм байгаа юу? Хэр ажиллаж байна вэ? Тэрүүгээр дамжуулаад хараат бус байдалд нөлөөлөх ийм асуудлууд байна уу ямар байгаа вэ? Тэгээд энэ хугацаанд сүүлийн 5 жилд огцрох ийм юу авсан шүүгч байгаа юу огцорсон? Хэдэн шүүгч байгаа вэ. Шүүхийн сахилгын хороогоор хэчнээн шүүгчийн асуудал шийдэгдсэн бэ гэсэн ийм асуулт байна.

Энэ 2 нэр дэвшигч маань их боломжийн нэр дэвшигч орж ирсэн байна гэж ойлгож байна. Нэлээн олон жил тийм шүүхэд ажилласан ийм улсууд байна аа.

Нэг нь Дээд шүүхэд очих гэж байгаа юм байна. Нөгөөдөх нь давж заалдах шатанд очих нь ээ. Та бүхэн чинь хөдөө орон нутагт ажиллаж байсан уу? Хоёулаа дээд үү? Нэг нь иргэний болон эрүүгийнх байх. Тэгээд та бүхэн маань.

Б.Энхбаяр: Эхлээд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Мөнгөнцэцэг. Тэр шүүгч нарт хэчнээн шүүгч сахилгын арга хэмжээ авсан бэ гэдэг асуудал бол Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрхийн асуудал.

Энэ нөгөө арга хэмжээ авдаг хүн нь биш шүүгчийг хуульчдаас шилж сонгож шалгаруулах асуудлыг нь хариуцаж байгаа. Мөнгөнцэцэг дарга хариулъя. Эхлээд 4 номерын микрофон.

Н.Мөнгөнцэцэг: Ганбат гишүүний асуултад хариулъя.

Шүүхийн ерөнхий зөвлөл хараат бус байдлыг хангах талтай холбоотой ямар ажил хийж гүйцэтгэж байна аа? Гүйцэтгэх засаглалаас хэрхэн нөлөөлж байгаа тухай мөн Сахилгын хороогоор шийдвэрлэсэн хэргийн талаар асуулаа гэж ойлголоо.

Үндсэн хуульд заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүгчийн хараат бус шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана гэж заасан байгаа. Тэгээд шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг хангахын тулд мэдээж гадаад дотоод хүчин зүйл нөлөөтэй. Албаны мөн түүнчлэн шүүгчийн хараат бус байдлыг хангахын тулд шүүхийн бие даасан байдал бол гарцаагүй чухал үүрэг гүйцэтгэж байгаа.

Тэгэхээр шүүхийн бие даасан байдал хангагдсанаар бас шүүгчийн хараат бус байдал хангагдана гэж бол ойлгогдож байгаа. Тэгээд энэ чиглэлээр шүүхийн бие даасан байдлыг хангах талаар бол Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хийж хэрэгжүүлсэн ажлын талаар бол товчхондоо дүгнээд хэлэхэд бол Шүүхийн ерөнхий зөвлөл нь 2021 оны Шүүхийн тухай хууль батлагдсанаар шинээр бүрэлдсэн 10 бүрэлдэхүүн маань 4 дэх жилдээ буюу энэ жил бүрэн эрхийн хугацаа дуусаж байгаа.

Энэ хугацаанд бол шүүхийн бие даасан байдлыг хангах чиглэлээр бол бодлого төлөвлөлтийн шинэчлэлийн талаар бол та бүхэн мэдэж байгаа. 2020, 2024 оны 6 сард бид хэд шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогоо батлуулж чадсан. Мөн үүнтэй уялдуулаад мөн түүнчлэн Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж чадсан байгаад байгаа.

Тэгээд энэ нэмэлт, өөрчлөлт орсноор бид хэд шүүхийн бие даасан байдлыг хангахтай холбоотой бүтэц, шүүхийн бүтэц, захиргааны бүтэц болон орон тоог өөрсдөө тогтоох тэр эрхийг олж авсан. Мөн түүнчлэн цалин нэмэгдлийг төсвийн хүрээндээ тохируулан шинэчлэн тогтоохоор заасан байгаад байгаа. үүний хүрээнд бид хэд шүүгчийн цалингаа бол нэмж чадсан гэдгийг зориуд хэлмээр байна аа.

Хоёрдугаарт хамгийн гол бид хэдийн хийгдэж байгаа асуудал бол шүүхийн цахимжуулалт байгаа. Энэ цахимжуулалтыг бол төр засгаас ч гэсэн дэмжсэн. Үүнтэй холбогдуулаад бид нар цахим шүүх 2.0 гэсэн цахим системийн энэ программыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Энэ систем маань эхний ээлжид хялбар ажиллагааны шүүхээс 2026 оны 6 сарын 30-ны өдрөөр нэвтрүүлэхээр ингээд бид бэлтгэл ажлаа хийгээд хангаад явж байна аа. Шүүгчийн хараат бус байдалтай холбоотой гүйцэтгэх засаглалаас ялангуяа нөлөөлсөн талаар асуулаа.

Тэгэхээр шүүгчийн хараат бус байдлыг хангах хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийн хүрээнд нийт 4 жилийн хугацаанд бол 1 дүгээрт шүүгч нар маань энэ хугацаанд бол Шүүхийн тухай хуульд заасан 45 дугаар зүйлд заасны дагуу бол нөлөөллийн мэдүүлгийг бол өөрсдөө мэдүүлэх ийм үүрэгтэй байгаад байгаа. Энэ хугацаанд 2022 оны 1 сарын 1-ээс хойш бол энэ хугацаанд 45 нөлөөллийн мэдүүлгийг давхардсан тоогоор 54 шүүгчээс хөтлөн ирүүлсэн байдаг. Үүнээс 2022 онд 15, 2023 онд 18, 2024 онд 8, одоо 2025 оны 6 сарын байдлаар 4 нөлөөллийн мэдүүлгийг ирүүлсэн. Энэ ирсэн эдгээр нөлөөллийн мэдүүлгийг бид хэд эрх бүхий байгууллагад шалгуулахаар явуулсан байгаад байгаа. Гэмт хэргийн шинжгүй гэсэн үндэслэлээр нөлөөллийн мэдүүлгийг бол хэрхэн хянан шийдвэрлэсэн талаар бол тоон мэдээллүүдийг та бүхэнд сонирхуулбал гэмт хэргийн шинжгүй гэсэн үндэслэлээр гэмт хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан нь нийт 14.

Б.Энхбаяр: Нэр дэвшигчээс асуусан. Ажлын туршлага, хөдөө орон нутагт ажиллаж байсан байдлыг Ганбат гишүүн асуусан. 5 номерын микрофон. Оч шүүгч.

Ц.Оч: Та бүхний энэ өдрийн мэндийг хүргэж байна. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Цогийн Оч. Миний хувьд 2006 онд БГД-ийн шүүхэд шүүгчээр томилогдсон, 2008-аас 2012 онд Дархан-Уул аймаг дахь Сум дундын шүүхэд Ерөнхий шүүгчээр, 2012-оос 2013 онд Хэнтий аймгийн шүүхийн ерөнхий шүүгчээр ажиллаж байсан. 2013 оноос өнөөдрийг хүртэл Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатын шүүхэд шүүгчээр ажиллаж байна. Орон нутагт бол ажиллаж байсан туршлага байгаа.

Б.Энхбаяр: 6 номерын микрофон Золзаяа шүүгч.

Э.Золзаяа: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Улсын дээд шүүхэд нэр дэвшигч Энэбишийн Золзаяа байна. Миний бие 2004 онд шүүгчээр томилогдсоноос хойш анхан шатад буюу нийслэлийн, дүүргийн, дүүрэгт ажиллаж байсан. Мөн давж заалдах шатад бол Нийслэлийн шүүхэд бол ажиллаж байгаа. Ийм учраас ажлын туршлага бол дандаа хотын буюу Улаанбаатар хотын хэмжээнд байгаа. Харин миний хувьд 2012 оноос бол иргэний шүүгч багшаар ажиллаж мөн 2014 оноос Монголын хуульчдын холбооны сургалтын хороонд багшаар ажилладаг. Энэ туршлагынхаа хүрээнд бол хөдөө орон нутагт явж сургалт зохион байгуулж байсан. Орон нутгийн хувьд болохоор Говь-Алтай, Баянхонгор аймагт очиж сургалт явуулаагүй. Бусад аймгуудад сургалт явуулж байсан. Ийм учраас хөдөө орон нутгийн шүүгч шүүхийн ажилтнуудынхаа ажил амьдралдаа тодорхой хэмжээнд.

Б.Энхбаяр: Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Би гол нь шүүхийн хараат бус байх талаар, шүүгчийн хараат бус байх талаар нэлээн гадуур дотуур их яригдаж байгаа л даа. Ингээд боломж олгох үүднээс та бүхнийг нэг сайн тайлбарлаасай л гэж ойлгоод байгаа юм ард түмэнд. Энийг чинь бүгд л хараад сонсоод хүлээлгээд сууж байгаа шүү дээ. Тэр талаар манай Энхбилиг дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Зүмбэрэллхам дарга нар их сайн тайлбарладаг байсан. Энэ их зүйтэй юм байгаа юм. Хэдэн хүн огцорсон бэ гэдгийг би асуугаад байгаа юм.

Шүүгч шүүгч нараас хэн ямар шийтгэл хүлээлгэчхэв. Энэ зөв байсан уу ямар байсан уу? Ахиад би 2 нэр дэвшигчээс асууя. Шүүгчийн хараат бус нөлөөлж байгаа юм уу иймд энэ талаар та бүхэн ямар бодолтой байна вэ? Хэвийн үйл ажиллагаа явуулахад өнөөдөр бол асуудалгүй юу? Хэн нэгэн шүүгчийг тэрний шүүгч, энэний шүүгч гээд л ингээд нэрлэдэг л дээ. Ийм байдаг. Та бүхэн чинь тэгээд хэчнээн хүнээс шалгаруулаад энэ 2 маань гарч ирэв гэсэн ийм асуулт байна.

Б.Энхбаяр: Ганбат гишүүний эхний асуулт хэчнээн шүүгч огцорсон бэ гэдэг асуудлыг бид нар Шүүхийн сахилгын хорооноос асууна. Хууль зүйн байнгын хороонд удахгүй Шүүхийн сахилгын хорооны төсөв. Үгүй үгүй энэ огцруулдаг газар нь Шүүхийн ерөнхий зөвлөл биш байхгүй юу. Сахилгын хороо байхгүй юу. Үндсэн хуулийн байгууллага болгочихсон тийм. Харин тийм Шүүхийн сахилгын хорооноос асуух ёстой болчихоод байгаа юм. Шүүхийн сахилгын хорооны тайлан төсвийг бид хаврын чуулганаар ХЗБХ хэлэлцэх юм. Бараг энэ 6 сардаа багтаад хэлэлцэх юм.

Тэр үед та Шүүхийн сахилгын хорооны гишүүдээс энэ талаар дэлгэрэнгүй тодруулах боломжтой байгаад байгаа юм.

2 дахь асуулт нь Ганбат гишүүн юу юу гэсэн билээ? Нэр дэвшигчээс асуусан уу? Та 2 нэр дэвшигч хариу хэлнэ. Эхлээд 5 номерын микрофон. Оч шүүгч.

Ц.Оч: Ганбат гишүүний асуултад хариулъя. Шүүхийн хараат бус байдалтай холбоотой асуудал асууж байна. Шүүгч бол аливаа хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хэнээс ч хараат бусаар шийдэх ёстой. Энэ зарчим бол олон улсын гэрээгээр ч тунхагласан шүүхийн шударга ёсны зарчим. Монгол Улсын үндэсний хууль тогтоомжуудаар тунхаглан заасан энэ шүүгч хараат бусаар хэргийг шийдвэрлэх ийм зохицуулалттай. Ер нь бол Монгол Улсын бүх шүүгч нар хараат бусаар ажиллаж чадаж байгаа гэж ойлгож байгаа.

Б.Энхбаяр: 6 номерын микрофон Золзаяа шүүгч.

Э.Золзаяа: Шүүгчийн хараат бус байдалд нөлөөлдөг 2 хүчин зүйл байдаг. Нэг нь гадаад буюу объектив хүчин зүйл нөгөөдөх нь дотоод буюу нөгөө субъектив хүчин зүйлүүд байдаг. Гадаад хүчин зүйлийн талаар бүгдээрээ сайн мэдэж байгаа. Гадаад хүчин зүйлийг юу вэ гэхээрээ шүүхийн эдийн засагтай холбож ярьдаг. Одоо ингээд хэвлэл мэдээллийн асуудлуудыг сөхөж ярьж байх шиг байна. Хэвлэл мэдээллийн асуудалтай холбоотой бол шууд нэрлэн зааж байгаа хүмүүсийг бол мэдээж Сахилгын хороо болон эрүүгийн журмаар шалгах энэ эрх нь нээлттэй байгаад байгаа. Тэр хүрээнд өргөдөл гомдлоо өгөөд шалгуулахад нээлттэй байгаа байх аа. Объектын хүчин зүйлийн хүрээнд ярих юм бол хувь хүний өөрийнх нь биеэ авч явж байгаа байдал ёс зүйн асуудал бол сөхөгддөг.

Ёс зүйн асуудлын хүрээнд бол Сахилгын хороо ажиллаж байгаа. Өргөдөл гомдлоо гаргах нь нээлттэй байгаа. Миний хувьд бол сахилгын арга хэмжээ авагдаж байгаагүй ээ. Тэр нөлөөллийн хүрээнд буюу нөгөө хараат бус байдалд халдаж байгаагаар холбоотойгоор бол судалгаа энэ тэр хийгдсэн байдаг юм байна лээ.

Б.Энхбаяр: Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Би Шүүхийн ерөнхий зөвлөлөөс нэг асуулт нэр дэвшигчдээс зүгээр 2 зүйлийг тодруулъя. Танилцуулгыг хийхдээ бас урьдчилаад орж ирж байгаа танилцуулагдаж байгаа хүмүүс маань ямар чиглэлээр мэргэшсэн бэ гэдгийг нь уг нь нэг хэлчхэж байвал их зүгээр байгаад байгаа юм. Тэгэхээр би Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүх дэх ерөнхийдөө шүүгч нарын судалгааны чиглэл ажлын байкграундаас аваад үзэхэд аль салбар эрх зүйгээр мэргэшсэн хүмүүс ер нь одоо хэдэн хувьтай байна вэ? Шалгалт авахдаа тодорхой салбар эрх зүйгээр заачхаад шалгалтад тэнцсэний дараа өөр танхим руу шилжүүлчихдэг ийм зүйлүүд ингээд байдаг гээд гадуур яригдаад байгаа юм.

Тэгэхээр одоо 2 нэр дэвшигч маань зүгээр Улсын дээд шүүхэд л гэж байгаа болохоос биш би очиж нэр дэвшигчийг яг Улсын Дээд шүүхийн Эрүүгийн танхимд томилогдох гэж байна ч гэдэг юм уу яг ингэж орж ирээгүй л байна л даа. Тэгэхээр энэ шалгалтуудыг авч байгаа агуулга цар хүрээг ер нь яаж тодорхойлж байна? Орон гарсан гэдэг юм уу захиргааны чиглэлийн, эрүүгийн чиглэлийн нэр дэвшигч шаардлагатай байна гэдэг үүднээс нь энэ агуулгыг тодорхойлоод байна уу? Эсвэл ерөнхийдөө аль ч салбар эрх зүйг хэрэглэх чадвартай байх ёстой гэж үзэж энэ

шалгалтуудыг авдаг юм уу? Шүүхийн ерөнхий зөвлөл Зүгээр олон нийтэд нэг энэ мэдээллийг өгчхөөч 1 дүгээрт.

Хоёрдугаарт яах вэ зүгээр нэр дэвшигчдийн хувьд заримыг нь жич ажлын хэсгүүд дээр хууль боловсруулах ажлын хэсгүүд дээр харж байсан мэдэж байсан хүмүүс л байна л даа.

Тэгэхээр энэ хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад ер нь шүүхийн оролцоо, чиг үүрэг, ач холбогдлыг нэр дэвшигчид маань юу гэж боддог вэ?

Дээрээс нь яах вэ сүүлийн үед бас бид хэдийн нэг ахиулах гээд байгаа жишээ нь эрүүгийн процесс дээр хэрэг шүүхээс буцдаггүй байх тэнд нь тиймээ нэг бол цагаатгадаг, нэг бол хавтаст хэргийн хүрээнд нотлох баримтын хүрээнд яг л гэм бурууд нь тохирсон ял хариуцлагыг нь хүлээлгэдэг байх. Энэ бодол дээр жишээ нь нэр дэвшигч маань юу гэж бодож байна? Оч нэр дэвшигчийн хувьд эрүүгийн чиглэлээр мэргэшсэн хүний хувьд тэгэхгүйгээр буцаадаг. Заавал нэг ийм жижиг шүүх өөрөө мөрдөн байцаах чиг үүрэгтэй оролцоод байдаг ийм хандлагууд оролцох бодолтой ийм саналууд ингээд өгөөд байх юм.

Та ер нь хувь хүнийхээ хувьд юу гэж боддог вэ? Золзаяа нэр дэвшигчийн хувьд би зүгээр л асууя. Иргэний процесс дээр жоохон иргэд жоохон бухимдалтай ханддаг хэрэг маргаан шийдэгдэхгүй байна, шийдвэр гүйцэтгэл явахгүй байна. Энийг та нэг яг нэг 5 пойнтоор гэдэг юм уу яг ийм 5 шалтгаанаас гэж байгаа юм гээд маш цомхон байдлаар өөрийнхөө итгэл үнэмшлээр нэг хариулж өгөөч. Юуг сайжруулбал болох вэ? Жишээ нь одоо яах вэ иргэний шүүх дээр шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг шүүх эрх мэдлийн байгууллагад байх ёстой гэж та боддог уу? Эсвэл энэ класс акшен буюу тодорхой ийм шүүхийн хялбаржуулсан гэдэг юм уу.

Б.Энхбаяр: Мөнгөнцэцэг дарга Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга 4 номерын микрофон.

Н.Мөнгөнцэцэг: Баярлалаа. Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Улсын дээд шүүхэд нийт томилгоотой 23 шүүгч байна. Ерөнхий шүүгчээ оролцуулаад. Захиргааны хэргийн танхимд бол одоо нийтдээ 7 шүүгч, иргэний хэргийн танхимд мөн адил 7 шүүгч, эрүүгийн хэргийн танхимд 8 шүүгч гэсэн ийм шүүгч харьяалан шүүн таслах ажиллагаа явуулж байна. Өмнө нь бол бид Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчээс мөн анхан, давж заалдах шатын шүүхийн шүүгчээс авдаг шалгалтын ялгаагүй хууль зүйн мэдлэг чадварын шалгалт, шүүгчийн ёс зүйн мэдлэг, мэргэжлийн ёс зүйн зан байдлын талаар бол ийм 2 шалгалт авч байгаа.

Хууль зүйн мэдлэг чадварын шалгалтын хүрээнд бол 4 үндсэн даалгавар хийгдэж байгаа. Энд хууль эрх зүйн мэдлэг чадварын шалгалт буюу бодлого. Эрх зүйн баримт бичиг боловсруулах, тогтоол бичих байгаад байгаа. Мөн түүнчлэн дүн шинжилгээ хийх буюу анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг санамсаргүй аргаар унагааж байгаа. Үүнд бол заавал дүн шинжилгээ хийгддэг байгаа. Мөн түүнчлэн 4 дэх шалгалт нь буюу Үндсэн хуулийн энэ бодлого бодох гэсэн ийм 4 чиглэлээр бол нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг чадварыг үнэлж байгаа.

Хоёрт шүүгчийн ёс зүйн мэдлэг чадвар хандлагын талаар бол нэг бол 14 шалгуур үзүүлэлтээр буюу 9 шалгуур үзүүлэлтийг бид нар шинжээчийн боловсруулсан асуултын дагуу асууж үлдсэн 5 асуултыг бол тухайн нэр дэвшигчтэй холбоотой илтгэгч гишүүний тайлан дүгнэлт болон бусад байгууллага юу нь эх сурвалжид үндэслээд бол тэр 5 үзүүлэлтийг дүгнэдэг байгаа.

Мэдлэг чадварын шалгалтын тухайд ийм байна. Манай нэр дэвшигч Оч шүүгчийн тухайд, нэр дэвшигчийн тухайд бол 2024 онд ноднин Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсны дагуу аль ч салбар эрх зүйн мэдлэгтэй байх шаардлагын дагуу шалгалтыг өгсөн байгаад байгаа. Эрүү, иргэн, захиргааны чиглэлээр дээрх тэр сая түрүүн миний хэлсэн 4 шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Золзаяа нэр дэвшигчийн тухайд болохоор дээд шүүхээс ирүүлсэн захиалгын дагуу иргэний чиглэлээр мэргэшсэн ийм нэр дэвшигчийг бид нар сонгон шалгаруулах байсан.

Тэгээд нэр дэвшигч Золзаяагийн тухайд болохоор дээрх 4 даалгаврыг иргэний эрх зүйн чиглэлээр бол хийж гүйцэтгэж ингээд тэнцэж орж ирсэн байгаа.

Б.Энхбаяр: 5 номерын микрофон Оч шүүгч хариулъя.

Ц.Оч: Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Миний хувьд 2010 оноос Монгол Улсын шүүхэд хэрэгжиж байгаа энэ шүүгч сургагч багш бэлтгэх хөтөлбөрт хамрагдаж эрүүгийн эрх зүйн чиглэлээр мэргэшиж, шүүгч нарт хичээл заах сургалт орохоор мэргэшиж байгаа. Энэ хугацаанд хүн худалдаалах гэмт хэрэг, эдийн засгийн гэмт хэрэг мөн хууль бус уул уурхай хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн чиглэлүүдээр тусгайлан сэдэв гарын авлага бэлтгэж сургалт орсон. Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах асуудлын хүрээнд энэ хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бол Улсын дээд шүүх хангах ийм хуулийн зохицуулалттай байгаа.

Тэгэхээр хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах асуудлаар бас энэ шат шатын шүүхээр шийдвэрлэж байгаа хэрэг маргаан.

Б.Энхбаяр: 5 номерын микрофон нэмж хариулъя.

Ц.Оч: Улсын дээд шүүхээр хянагдаж байгаа энэ хэргүүдэд бол нь судалгааны нэлээдгүй тийм том объект болдог. Тэгэхлээр энэ судалгааны ач холбогдолтой гэж ойлгож байна. Хэргийг шүүхээс мөрдөн байцаалтад буцаагдахгүй байх асуудлын талаар Сайнзориг гишүүн асуулаа.

Энэ асуудал бол эрх зүйн тогтолцооны хувьд эх газрын системтэй орнуудын хувьд болохоор хэргийн үнэнийг бодит үнэнийг тогтоох ийм тогтолцоотой. Манай улс бол эх газрын эрх зүйн системтэй жишгийн эрх зүйн системгүй учраас энэ хэргийн бодит үнэнийг тогтоох ийм тогтолцоо байгаа. Тэгэхээр энэ тогтолцооны хувьд тогтолцооноос шалтгаалаад эрх зүйн хувьд ийм өөр өөр байр суурь хуулийн зохицуулалтууд гараад байгаа.

Мөрдөн байцаалтын шатанд прокуророос шилжүүлсэн хэрэг.

Б.Энхбаяр: 6 номерын микрофон Золзаяа шүүгч хариулъя.

Э.Золзаяа: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь 2002 онд батлагдсан. Цөөн тооны өөрчлөлт орж байсан. Тэрнээс биш өнгөрсөн жил болон өмнөх жил тусгайлсан журмын өөрчлөлт орсон. Тэрнээс бол өөр нэг гол гол өөрчлөлтүүдийг оруулаагүй. Одоо ер нь бол энэ хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэж үздэг. Хэд хэдэн ажлын хэсэг байгуулагдаж байсан. Тэгэхдээ энэ хууль маань өөрөө төдийлөн одоо хүртэл бол өөрчлөгдөж байгаагүй байгаа.

Товчхон хэлэхгүй бол нөгөө цаг бага байгаа учраас. Нэхэмжлэлийг хүлээж авах энэ ажиллагаанд бол саадтай байсан. Энэ бол бухимдлыг төрүүлж байсан. Энэ бол одоохондоо бага хэмжээгээр арилсан гэж үзэж байгаа. Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хотын 6 дүүргийн хүрээнд хялбар хэргийн шүүх ажиллаж эхэлж байгаа. Үүнтэй холбоотой 6 энэ ачаалал ихтэй 6 дүүргийн хүрээнд л орох болохоор яг хэргийн ачаалал буурах магадлалтай байгаа учраас одоо энэ шүүгч нараас хэргийн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах энэ ажиллагаа багасах байх гэж бодож байгаа.

Шинэчлэлийн хүрээнд юу хэрэгтэй вэ гэвэл урьдчилсан шүүх хуралдаан хэрэгтэй байгаад байгаа юм. Хэрэг хянан шийдвэрлэх энэ иргэний хэрэг шүүхэд.

Б.Энхбаяр: Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Нөгөө цаг багадаад жоохон хариултууд нэг таслагдаад явчих шиг боллоо. Яах вэ би чуулган дээр бас яг энэ асуултаа л асууя гэж бодож байна аа. Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар бол аль нэг танхимд хуваарилдаггүй шиг санаж байна. Зүгээр Улсын Дээд шүүхийн шүүгчээр томилсугай гэж гарах байх. Тэгэхээр ингээд магадгүй зүгээр жишээ нь Оч шүүгч бол захиргаа юм уу, иргэн рүү л орж ажиллах юм болов уу? Би зүгээр мэдэхгүй байна л даа. Ер нь зүгээр эрүүгээрээ суурилад явлаа гэхэд энэ мэтгэлцээний үндсэн дээр энэ хавтаст хэргийн хүрээнд цугларсан нотлох баримтын хүрээнд л хэргийн бодит үнэнийг тогтоодог энэ зарчмаа Дээд шүүхийн шүүгч бол баримталж ажиллаарай.

Түүнээс биш нэг л юм дутуу байна гээд нэг яллачих гээд, нэг л юм дутуу байна гээд ингээд хэргийг буцаадаг энэ хандлагыг анхаарч өгөөч ээ. Ер нь ингээд шүүгч нар л энийг зөв бодож хэрэгжүүлж байж л энэ асуудлууд цэгцрэх байх. Яах вэ Золзаяа шүүгчийг би мэднэ л дээ зүгээр энэ иргэн чиглэлээр нэлээн ажиллаж байсан. Тэгээд би ер нь зүгээр энэ процессын эрх зүй талдаа бас.

Б.Энхбаяр: Уянгахишиг гишүүн асуултаа асууя.

Г.Уянгахишиг: Би нэг богинохон л юм асуух гээд байгаа юм. Өмнө нь 8 сард шиг санагдаад байна. Яг юуг нь санахгүй байна л даа. Ямар ч байсан ингээд нөгөө нэрийг нь сонсоод танилцуулгыг нь ингээд харахаар өмнө нь яг Хууль зүйн байнгын хороогоор орж ирж байсан. Тэгэхээр яг одоо яагаад дахиж орж ирж байгаа юм бол. Бид нар чинь Байнгын хороогоор ороод, чуулганаар ороод амжилт хүсье гээд явуулсан санагдаад байгаа байхгүй юу. Тэгээд тухайн үедээ ч гэсэн Золзаяа шүүгчээс бол нэлээн тодруулга авч асуултууд асууж байсан. Тэгэхээр яг энэ тал дээр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс асуумаар байна. Яагаад нөгөө шүүгч маань дахиад ороод ирж байгаа билээ? Асуудлын гол нь юу байгаа билээ гэдгийг.

Б.Энхбаяр: Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Мөнгөнцэцэг. 4 номерын микрофон.

Н.Мөнгөнцэцэг: Золзаяа нэр дэвшигчийн тухайд бол өмнө өргөн мэдүүлээд Улсын Их Хуралд танилцуулахаар орж ирсэн байгаа. Нөөцийн онооноос шууд өргөн мэдүүлэгдсэн учраас Ерөнхийлөгчийн Тамгын газраас Ерөнхийлөгчид танилцуулах боломжгүй. Энэ талаар мөн түүнчлэн ҮХЦ дээр гомдол гарсан учраас ийм юутай цэц дээр хэрэг үүсгэсэн байдалтай байгаад байгаа. Тэгээд өнөөдөр Шүүхийн тухай хуулийн 34.9-д заасны дагуу оноо бол өөрөө нөөцийн оноо бол хүчинтэй байгаа учраас энэ хүнийг өөрийн нь хүсэлтийн дагуу 2-т эрэмбэлэгдээд орж ирж байгаа байгаа юм.

Б.Энхбаяр: Уянгахишиг гишүүн тодруулж асууя.

Г.Уянгахишиг: Саяын тайлбарыг жоохон тодруулж болох уу? Одоо нөгөө нэг ҮХЦ дээр байгаа гэдэг чинь хуулийн заалт нь байгаад байдаг. Тэрийг нь ҮХЦ-д оччихсон гэсэн үг үү? Тэгээд яг ямар учиртай юм бол? Бид нарын ойлголтоор өмнө нь тайлбарлахдаа бол тухайн үеийн журам дүрмийнхээ дагуу тэр нөөцөд байгаа тохиолдолд шүүгчээ томилоод ингээд явдаг гээд л оруулж ирээд л ингээд л хэлэлцүүлээд л чуулганаар ч гэсэн хэлэлцүүлээд явуулж байсан шүү дээ тиймээ?

Тэгэхээр энэ нь яг ямар асуудал байдаг юм бол? Энийг ойлгоод авчихмаар л байна л даа тиймээ?

Б.Энхбаяр: 4 номерын микрофон Мөнгөнцэцэг дарга тодруулж хариулъя.

Н.Мөнгөнцэцэг: Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсны дагуу нөөцөөс бол нэр дэвшүүлэх боломжтой болсон. Үүний дагуу нөгөө энэ хуулийг буцаан хэрэглэх эсэх дээр маргаантай байгаад байгаа. Тэгээд манай нэр дэвшигчийн Золзаяа нэр дэвшигчийн тухайд болохоор сонгон шалгаруулалт явуулахгүйгээр шууд нөөцөөс өргөн мэдүүлсэнтэй холбоотойгоор тэрэн дээр асуудал гарсан. Тэгээд энэ удаад 2 дахиа сонгон шалгаруулалтдаа процесст эхнээсээ ороод ингээд бүртгүүлээд ингээд нөөцийн оноогоороо эрэмбэлэгдээд орж ирж байгаа.

Б.Энхбаяр: Түрүүн Эрдэнэболд гишүүний нэр өгөгдсөн байсан. Техникийн саад гарсан байсан. Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Шүүхийн индекс гаргаж байгаа. 2023 оны шүүхийн индекс. 6 хэмжигдэхүүн, 42 дэд хэмжигдэхүүн, 108 шалгуур үзүүлэлт гэж гараад 2021 оны суурь судалгаагаар Монгол Улсын шүүх 100 онооноос 51.94 оноо авсан.

2023 онд 53.22-той болсон байгаа юм. Шүүхэд итгэх итгэлийн судалгааг 2021 оноос хийж эхэлсэн байна лээ. Ер нь бол тэр юуны Ворлд жастист прожектын гаргасан судалгаагаар бол манай улсын энэ жастис ранк буюу хэмжүүр нэг дэлхийд 75 дугаар байрт одоогоор явж байна. 46 оноогоор.

Нэгд Швед 81 оноо. Тэгэхээр 1 түрүүлж байгаа улсаас бол нэг 30-аад онооны зөрүүтэй гэсэн үг. Тэгэхээр Шүүхийн ерөнхий зөвлөл ер нь энэ цаашдын шүүхэд итгэх итгэл дээрээс нь энэ шүүх өөрөө төрийн нэрийн өмнөөс шийдвэр гаргаж байгаа төрд итгэх итгэлийн гол толь хэмжүүр байдаг. Энэ дээр ер нь Шүүхийн

ерөнхий зөвлөл одоо 2025 онд ер нь цаашдаа энэ оноо өсөхөөр байна уу, уруудахаар байна уу? Энэ ямар түвшинд байна? Энэ тал дээр ер нь Шүүхийн ерөнхий зөвлөл яг юу хийж байгаа юм бэ.

Хоёрдугаарт, би энэ 2 хэрэгтэй хэргийн сүүлийн үед нөгөө хүний эрхийн дэд хорооноос болоод нэлээн олон шүүх хурлууд дээр ажиглагчаар орж суулаа. Сайн муу 2 жишээ. Муу жишээг нь эхлээд хэлэхэд Зам, тээврийн сайд байсан Энх-Амгаланд холбогдох хэргийн шүүх хурлыг ажиглалаа. Өмгөөлөгч нь тэгээд хүмүүс ингээд яриад хэдэн цагийн турш яриад яриад байхад шүүгчид нь танин мэдэхүйн зүйлүүд ярьсан зүйлээс нь ухаж ойлгох чадваргүй дахин дахин асуугаад л байх юм. Хэрэгтэйгээ ингээд нарийвчилж танилцсан юм нь аягүй ховор.

Тэгээд өчнөөн яриад энэ чинь хүний ингээд эрүүл мэнд, амь нас, эрх чөлөөгөөр хэмжигдэж байгаа зүйл дээр их хариуцлагатай баймаар юм байна даа гэсэн тийм мэдрэмж төрсөн.

Сайн жишээ нь сая Батчулуун эмчийн хэрэг дээр тэр нийслэлийн тэргүүн шүүгч шийдвэр гаргахдаа тэр үндэслэл хэсгийг аягүй сайн тайлбарлаж байна лээ. Ийм ийм учраас хуулийн хэллэгээр bond reasonable draft гэж хэлдэг. Няцаагдашгүй нотлох баримт ийм ийм байгаа учраас өмнөх шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож хүмүүсийг Батчулуун эмчийг жишээлбэл цагаатгаж байгаа юм.

Тэгэхээр Улсын дээд шүүхийн өөрийнх нь энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн веб сайт дээр энэ улс орнуудын шүүхийн шийдвэрт танилцуулах арга зүй ба туршлагын талаар ийм лавлагаа бичсэн байгаа. Япон болон бусад улсуудын гээд.

Тэгэхээр яагаад энийг ярьж байгаа вэ гэхээр зарим нэг улс төрийн дуулиан шуугиантай хэргүүд бол далд байж байгаад л гэнэт зарлачихаар хүмүүс эргэлздэг. Өө энэ улс төрийн захиалга явчихлаа гээд нөгөө шүүхийн нэр хүнд унаад байдаг. Зарим нэг цөөхөн тохиолдол дээр шүүгч нь яг үндэслэлээ маш сайн тайлбарлаад байгаа юм. Энийг цаашаагаа нэг хэв мөр болгож болох уу? Энэ бол Шүүхийн ерөнхий зөвлөлөөс асууж байгаа асуулт.

Хоёр нэр дэвшигчээс тодруулга дээр асуулт асууя.

Б.Энхбаяр: Асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Мөнгөнцэцэг хариулна. Эхний асуултад, 2 дахьд 2 тодорхой хэрэг учралтай холбоотой асуултад Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл болон нэр дэвшигч шүүгч нар хариулт өгөх боломжгүй гэдгийг сануулъя.

Мөн хууль тогтоогч шүүн таслах үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглосон ийм үйл ажиллагаа үг хэл яриа гаргах нь хуулиар хориотой гэдгийг сануулъя. 4 номерын микрофон. Мөнгөнцэцэг дарга.

Н.Мөнгөнцэцэг: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Шүүхэд итгэх олон нийтийн итгэл ер нь ямар байгаа талаар судалгааны байгууллагуудын юуг асууж байна?

Тэгэхээр шүүхийн индексийн тухайд болохоор 2 жил тутамд нэг удаа гаргадаг. 2021 онд бол шүүхэд итгэх итгэл олон нийтийн итгэл бол 53.17 байсан бол 2023 онд 58.4 болж буурсан байгаа. Үүний талаар бид хэд шүүхэд итгэх итгэлийг

нэмэгдүүлэх талаар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ямар үйл ажиллагаа ямар бодлого барьж байна гэж асууж байна.

Тэгэхээр шүүхийн нээлттэй ил тод байдлыг хангах тал дээр бид нар бол хөтөлбөрийг баталж хэрэгжүүлж байгаа. Тэгээд шүүхийн үйл ажиллагаа иргэдэд ойлгомжтой хүрэх чиглэлээр хийсэн нэг гол ажлын нэг бол шүүхийн шийдвэр буюу процессын хураангуйгаа бол бэлтгэн мэдээлж байгаа. Мөн Улсын Дээд шүүхтэй хамтраад 2022 оноос эхлүүлснээр шүүхийн шийдвэрийн 2300 гаруй тоймыг бэлтгэн шүүхийн цахим хуудсаар хүргээд байна. Олны анхаарал татсан хэргийн шийдвэрийг шуурхай мэдээлэх зорилгоор шүүхийн мэдээ пэйж хуудас болон твиттер хуудсаар дамжуулан явуулж байгаа.

Энэ пэйж хуудасд одоогоор 18 мянга гаруй, твиттерт бол мянга гаруй дагагчтай болсон байгаад байна аа.

Хэвлэлийн бага хурлыг бол манай Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тогтмол хийж байгаа. Энд 4 жилийн хугацаанд бол 12 удаа хийсэн байгаад олон нийтэд бол олны анхаарал татсан. Энэ хэргийн талаар болон сэтгүүлчдийн асуултад хариулж байгаа. Мөн шүүхэд итгэх олон нийтийн илтгэлийг хангах хүрээнд Шүүхийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн нэг гол зүйл бол шүүх хуралдааныг бол бид нар нээлттэй дамжуулж эхэлсэн байгаа.

Авлигал албан тушаалын гэмт хэргийг анхан болон давж заалдах шатын шүүх мөн түүнчлэн хяналтын шатын шүүх бол бүх хэргүүдээ бол шүүх хуралдаанаа нээлттэй дамжуулж эхэлсэн. Энэнтэй холбоотой шүүхэд итгэх олон нийтийн итгэл нэмэгдэнэ гэдэгт бид нар итгэлтэй байгаа. Мөн түүнчлэн түрүүн би ярьж байсан. Манай шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогоо батлуулж чадсан. Энэ бодлогоо батлуулж чадсан учраас энэ асуудал маань өөрөө залгамж халаатай тэгээд цаашид шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх тал дээр энэ мэтчилэн олон ажил хийгдэхээр бол төлөвлөгдсөн байгаа гэдгийг хэлмээр байна аа. Мөн түүнчлэн энэ авлигын төсөөллийн индекс бол Трансперенси интернэйшнал байгууллагаас гаргадаг байгаа.

Энэ дээр бол 2024 оны үзүүлэлтээр бол 114-д орж энэ үзүүлэлт сайжирсан байгаа гэдгийг би зориуд энэ хугацаанд энэ боломжийг ашиглаад хэлэхийг хүсэж байна аа. Баярлалаа.

Б.Энхбаяр: Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Энхбаяр дарга би хуулиа мэдэж байгаа. Зүгээр яг тодорхой хэргүүдийн тухай асуугаагүй. Ийм жишээ байна аа. Ингээд битүү хатуу байгаад байхаар иргэдийн төрд итгэх итгэл, шүүхэд итгэх итгэл бол их тийм скандалтай байна.

Б.Энхбаяр: Уучлаарай Эрдэнэболд гишүүн ээ Энх-Амгалан, Зандаахүүгийн Энхболд нарын хэрэг эрүүгийн хэрэг шүүн таслах ажиллагаа явагдаж байгаа хэрэг. Тодорхой шүүхийн эцсийн шийдвэр гараагүй хэрэг учрал дээр шүүхийн хараат бус байдалд нөлөөлөх шинжтэй үг хэллэг дүгнэлт өгөх ийм байр суурь өгөх нь Үндсэн хуулиар хориотой. Шүүхийн тухай хуульд зааснаар хориотой.

Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Тэгэхээр гол нь бид нар нэг 10-аад жилийн өмнө жишээлбэл одоо Дээд шүүхийн шийдвэр ил тод байгаад тухайлбал одоо жишээ нь тухайн үед яригдаж байснаар АНУ-ын хуулийн сургууль жишээлбэл Дээд шүүхийн гаргасан тодорхой шийдвэр дээр аль шүүгч дэмжсэн, дэмжээгүй, тэгвэл яагаад дэмжсэн, эс үгүй бол яагаад дэмжээгүй вэ гэдэг дээр аягүй тодорхой анализ хийх боломжтой байсан. Тэр анализ хийх боломж олгосноороо бол олон нийтийн зөвхөн нөгөө сошиалаар ч явдаг ч гэдэг юм уу ил тод шүүх хурал явахаас илүүтэйгээр тухайн кэйс дээр задлан шинжилгээ хийх боломжууд ил тод нээлттэй гардаг байсан. Энэ илүү сайн байхын хэрээр уг нь бол нөгөө шүүхэд итгэх итгэл, төрд итгэх итгэл бол их гардаг гэдгийг л хэлэх гээд байгаа санаа нь.

Яах вэ мэдээж бол нээлттэй болж байгаа. Одоо бол шүүх хурлуудыг ил тод цахимаар үзэж байгаа нь бол сайн хэрэг. Тэрэн дээр бас гол нь тэр нөгөө шийдвэр гаргахдаа тодорхой одоо жишээлбэл, сонгуулийн өмнө уламжлал, ёсоороо, Зоригийн хэрэг гарч ирдэг. Сонгуулийн өмнө уламжлал ёсоороо, улс төрчтэй холбоотой асуудлууд гарч ирдэг. Ингээд л...

Б.Энхбаяр: Үг хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон нэр дэвшигчдэд хандаж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Ганбат гишүүнээр тасаллаа. Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн үг хэлье. Уучлаарай Эрдэнэболд гишүүн үг хэлье.

С.Эрдэнэболд: Тэгэхээр ер нь бид нар энэ яах вэ Дээд шүүх төрийн 3 өндөрлөг гээд л Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Ерөнхий сайд гээд байдаг ч гэсэн энэ амны уншлага болчихсон байдаг. Ер нь бол энэ чек энд баланс буюу засаглалын тэнцвэртэй байх харилцан хяналт тавих энэ онолын дагуу бол Дээд шүүх чинь бол харин засаглалын том ер нь бол зарчмын хувьд бол Дээд шүүхийн ерөнхий шүүгч бол төрийн 3 өндөрлөгийн нэг байх ёстой юм л даа. Ер нь зүгээр зарчим нь хандлагын хувьд бол. Шүүх гэдэг чинь Дээд шүүх гэдэг чинь бол шударга ёсны дээд илэрхийлэл. Тэр аль болохоор энэ шүүхэд итгэх иргэдийн итгэл илүү сайн бэхжих тусам энэ төрд итгэх итгэл цаашлаад энэ Монгол Улсын Үндсэн хуульт ёс энэ парламентын засаглал гээд өөрөөр хэлбэл энэ чек энд балансын хэвийн ажиллах горим бол энэ дээд шүүхтэй холбоотой. Тэгэхээр ер нь яах вэ би сая минутаа буруу тооцчихлоо.

2 шүүгчдээ амжилт хүсье. Та 2-оос асуух гэж байсан асуулт байгаа. Чуулганы танхимд асууя. Ер нь энэ сүүлийн судалгаагаар шударга ёс гэж асуунгуут л маш олон янзаар хариулдаг. Энэ шударга ёс гэнгүүт л энэ шүүхийн, шүүгчийн тэр үнэлэмж гэхээс илүүтэйгээр гудамжинд популизм хийж байгаа хүмүүсийн л хаяг адресс, халаасны шошго болчихсон яваад байгаа.

Тэгэхээр тэрүүгээр нөгөө нэг олон нийт чинь шударга ёсыг үнэлж хараад байна аа. Ихэвчлэн улс төржүүлж хараад байна. Явцуу ашиг сонирхолд хараад байна. Тэгэхээр аль болох тэр популистуудын амны уншлага болсон тэр ярилкыг нь ховхолж авч үнэхээр энэ хуулийн өмнөөс шийдвэр гаргадаг энэ шүүх гэдэг өөрөө бол хамгийн олон талаас нь тунгааж бодсон ололттой, амьдралтай тэгээд дээрээс нь бол зөвийг дэнсэлж чадсан, зөв бурууг дэнсэлж чадсан байх энэ итгэл үнэмшлийг л олон нийтэд өгөх тусмаа бид энэ сошиалын янз бүрийн ийм үзэн ядалтын энэ хар муу сүүдэр галзуурлаас гарах юм л гэж үзэж байгаа юм.

Тэр утгаараа бол бид нар энэ Дээд шүүх хэвийн ажиллахад бие даасан хараат бус ажиллахад нь бол аль болохоор анхаарч байх ёстой гэж бодож байгаа. Тэгэхээр тэр утгаараа бол Дээд шүүхийн шүүгчид маань ч гэсэн ямар ч нөлөөнд автахгүйгээр итгэл үнэмшилтэй хандаасай гэж бодож байгаа. Түрүүн Энхбаяр даргын хэлж байгаа тайлбарыг би хүлээж авлаа. Нөгөө болж байгаа хэрэг учраас болчихсон хэрэг дээр анализ хийх нь зөв байсан байна гэж харж байна. Тэгэхээр бол та бүхэндээ амжилт хүсье ээ.

Үнэхээр олон жил 55 настай хорин хэдэн жил шүүхийн салбарт ажилласан. Нөгөөдөх нь бол 20 шахам 10 нэлээн гаран жил ажиллаж байгаа. Яг мерит зарчмаараа бол анхан, дунд шатанд нь ингээд яваад давж заалдах шатдаа ирэхэд Золзаяа шүүгчийн хувьд бол яг 11 жил ажиллаад ингээд явж байгаа юм байна. Тэгээд та бүхэнд итгэж найдаж байгаа шүү. Тэгэхээр аль болохоор энэ скандал улс төрийн савлагаа энэ бүх зүйлээс ангид хол байгаарай л гэж хичээнгүйлэн хүсье ээ. Баярлалаа.

Б.Энхбаяр: Ганбат гишүүн үг хэлье.

Д.Ганбат: Шүүх шүүгчийн хараат бус байдал их аягүй чухал аа. Оч, Золзаяа 2 шүүгч дээр Улсын дээд шүүхэд очих юм байна. Энэ 2 шүүгчийн талаар би янз бүрийн юм дуулж байгаагүй ээ. Тийм учраас их боломжийн шүүгчид очиж байгаа юм байна гэж ойлголт авлаа. Тэгэхгүй бол одоо бас Улсын дээд шүүхэд очиж байгаа шүүгч нар хэн нэгэн хүний нэрийг зүүж явдаг ийм юм урьд нь байсан. Энэ байдал бол ялангуяа энэ одоогийн Ерөнхийлөгчийн үед байхгүй байгаа. Бид нар гашуун туршлага бий. ҮАБЗ хуралдаад давж заалдах болон Улсын Дээд шүүхийн шүүгч нарыг бөөнөөр нь халж байсан тохиолдол ч бий. Уул нь тийм байх ёсгүй. Тэр үед Шүүхийн ерөнхий зөвлөл энэ тэр дуугардаггүй байсан шүү. Шүүхийн ерөнхий зөвлөл бол хуулиараа шүүхийн хараат бус байдлын талаар энэ хууль тогтоомжийг сайжруулах талаар байнга санаа оноогоо тавьж байх ёстой. Энэ талаар ярьж байх ёстой. Хууль тогтоогчид бид нар тэр болгон тэр юмыг мэдэхгүй ээ. Ийм үүднээс л би асууж тодруулж асуугаад байгаа шүү дээ. Энэ байдлыг олон нийтэд ойлголтыг нь зөв өгөх ёстой. Тэгэхгүй бол олон нийт шөнөжингөө гэртээ хоносон шүүгч ийм өндөр цалин авдаг.

Гэтэл одоо шөнөжингөө жижүүрт гарсан эмч яагаад ийм бага цалин авдаг вэ гэж ярьдаг байхгүй юу. Өчнөөн олон эрх хэмжээгээ шүүгч нар хязгаарлуулдаг. Энийг байнга тайлбарлаж өгч байх ёстой. Шударга ёс хаана тогтож байх ёстой юм. Шударга шүүхээр шүүлгүүлэх эрх бол Монгол Улсын иргэн болгонд байх ёстой. Шүүхийн өмнө бүгд эрх тэгш ээ. Гэтэл шүүгч нар маань хараат бус байж чадаж байна уу үгүй юу? Энэ сүүлийн үед арваад жил нэг нам эрх барьсан. Хэтэрхий олонх байсан.

2012-оос 2016 онд Ардчилсан нам эрх барьж байхад би Хууль зүйн байнгын хороон дарга байхад тэр авлигын индекс энэ тэрээр 77-д орж байсан шүү. Тэр үед шүүхэд итгэх итгэл бол маш их сайжирч байсан. Одоо бол сүүлийн үед тийм юм байхгүй ээ. Авлигаар бол та их сайжирч байгаа юм шиг юм ярилаа. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, тийм биш ээ. Тэр оноо юм нь яг л хэвээрээ байгаа шүү дээ. Тэр олон орныг эзлүүлдэг болоод л ганц 2 байр нааш цаашаа болж байгаа байхгүй юу. Ийм ойлголттой байж болохгүй шүү.

Шүүхийн сахилгын хороон дээр 5 жил ажиллачихлаа. Энэ Шүүхийн сахилгын хороо маань яг хуульд нийцсэн шигээ ажиллаж чадаж байна уу үгүй юу. тэр 9 хүн томилж байгаа. Тэрний 5 нь албан тушаалтнуудаас томилоод байгаа байхгүй юу. Энэ хүмүүс очихоороо яг тэгж ажиллаж байна уу, хэн томилсон, томилгоо хийсэн, тэд нарын нөлөөллийг тэнд аваачаад шүүгчид нөлөөлөөд байна уу гэсэн ийм асуултыг л би тодорхой болгох гээд байгаа шүү дээ. Энийг энэ дээр бид нар ярьж байх ёстой. Сайжруулахын тулд санаа оноогоо хэлж байх ёстой. Ийм л зүйлийг ярих гээд байгаа юм аа. Тэгэхгүй бол бас шүүх шүүгчид итгэх итгэл байхгүй болж байна аа. Тэр байтугай гүйцэтгэх засаглалаас сайд нар нь энэ шүүх л болохгүй байгаа юм шиг, энэ шүүх ингэж ажиллаж байна гэж ярьж байгаа. Хэрвээ тэгж хэлж л байгаа бол шүүх хараат бусаар ажиллах гэж хичээж байгаа юм байна гэсэн ойлголт байх ёстой. Шүүмжилж л байгаа бол. Тэгээд Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг, Шүүхийн сахилгын хорооны даргыг 1, 1 жилээр ээлжилж байгаа байх. Энэ зөв ч юм уу ямар байгаа юм тиймээ энэ талаар бид нар ярих ёстой. Нөгөөдөх нь 4 жил, нэг нь 6 жил байгаа. Энэ яг ямар вэ гэдэг талаар бид нар хоорондоо ярилцаж хууль тогтоогчид бид нар энэ дээр үнэлэлт өгч сайжруулах юмаа сайжруулах...

Б.Энхбаяр: Сайнзориг гишүүн үг хэлье.

П.Сайнзориг: Шударга байх, аливаа зүйлд яг хуулийн үндэслэлтэй хэлчихдэг үнэнийг хэлчихдэг ийм хүмүүст бол бас энэ нийгэм жоохон халгаатай байгаа. Энэний эцсийн хамгаалалт нь шүүх засаглал байдаг юм аа. Тэгээд би энэ шүүх засаглалын оргилд нь очиж ажиллах гэж байгаа оргилд нь гэдэг нь тийм том хариуцлага байх нэг их эрх мэдэл биш байх аа. Энд очиж ажиллахаар нэр дэвшиж байгаа 2 хүмүүст амжилт хүсье. Би нэг зүйлийг л хүсэж байгаа юм.

Монгол Улсын эрх зүйн тогтолцооны цаашдын хөгжлийн чиг хандлага тогтвортой байх энэ асуудал энэ бас Улсын Дээд шүүхийн оролцоо хандлагаас их шалтгаалж байгаа. Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бид нар Улсын Дээд шүүхээс энэ гаргаж байгаа шийдвэрээрээ дамжуулж зөв гаргаж чадвал энэ хуулиудыг байн байн хүрээд байхгүйгээр зөв голдиролдоо ордог энэ дэлхий нийтийн жишиг хандлага байж байгаа. Энэ цагаан дээр хараар бичиж байгаа энэ текстийг хэдэн ч удаа өөрчлөгдөөд асуудал шийдэгддэггүй. Энийг хэн давуу байдалтайгаар тайлбарлаж өөртөө ашигтайгаар тайлбарлах тэр боломжийг олгохгүй байх ганц гарц Улсын дээд шүүх буюу эцсийн шийдвэрээр хууль хэрэглээний нэгдмэл байдлыг гаргаж байгаа явдал.

Тэгээд энэ ажил дээр очих гэж байгаа хүмүүст амжилт хүсье. Тэгээд бид нар яг та 2-ыг нэр дэвшигчийн танилцахаас өмнө хууль тогтоомжийн хувьд яг л энийг ярилаа. Хууль тогтоомжийн системчлэл энэ тогтворгүй байдлыг л шийдэхийн тулд нэмэлт, өөрчлөлт явсан энэ маргаан дагуулж байна. Гэхдээ хамгийн том хөшүүрэг нь Улсын дээд шүүх буюу шүүх эрх мэдэл өөрөө энэ хуулийн нэгдмэл байдлыг л хангаж байж энэ парламентаас гарч байгаа хууль хэлбэрэлтгүй хэрэгждэг ийм зүйл байдаг. Тэгэхээр энэ дээр нэр дэвшигчид маань анхаарч ажиллаж өгөөрэй. Тэгээд ялангуяа Улсын дээд шүүхийн энэ хуулийн нэгдмэл хэрэглээг хангахаас гадна хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажилд илүү их манлайлж оролцдог байгаасай. Энийг ч гэсэн бид нар хууль эрх зүйн талаас нь жоохон ойлгомжтой болгож өгөөсэй. Энд ирэхээр ажлын хэсгийн гишүүд шат шатын шүүгчдийг ингээд барьж идээд байдаг байхгүй юу, загнаад.

Тэгээд энэ сүүлдээ ингээд халгадаг. Ер нь зүгээр энд дуудагдах нь бараг шүүгч нарын хувьд ядаргаатай гэдэг юм уу ял мэт байгаад байгаа юм. Тэгэхээр уг нь энэ хууль хэрэглээний практик, зовлонг нь мэдэж байгаа хүмүүсийг л илүү их боловсруулах ажил дээр зүгээр татан оролцуулж саналыг нь сонсдог. Түүнээс биш яг шүүгчдийн заавар чиглэлээр бүх юмыг хийх гээд байгаа зүйл биш. Энийг ингээд баланстэй авч үзээд явдаг байх нь чухал байгаад байгаа юм.

Тийм учраас би энэ нэр дэвшигч нарыг Улсын Дээд Шүүх дээр очоод томилогдсон тохиолдолд энэ хууль боловсруулах энэ эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажилд битгий хойш суугаарай идэвхтэй оролцож байгаасай гэж хүсэж байна. Энэ туршлага мэдлэгээ шат шатад нь хувь нэмрээ оруулж байх ёстой гэж би хувьдаа бодож байгаа. Тийм учир энэ нийгмийн шударга байдал үнэн үг хэлсэн хүмүүсийн эцсийн зогсоол хамгаалалт нь шүүх эрх мэдэл та бүгд шүү. Тэгээд энэ нийгэм дээр нэг жоохон шулуухан хэлчихдэг ийм үзэгдлүүдийг нухчин дарах үзэгдэл байна. Энэний бат хамгаалалт цайз нь та бүгд байх болтугай гэж хүсье. Баярлалаа.

Гишүүд үг хэлж дууслаа. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчидтэй танилцаж дууслаа.

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Сайнзориг гишүүн танилцуулъя аа.

Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

13.20 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА